

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-50
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	12-13
2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	13-24
3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	24-32
4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	32-49
5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	49-50

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
06 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 43 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга;
Чөлөөтэй: Ж.Баясгалан, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Ч.Номин,
Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Б.Түвшин.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хэлэлцэх асуудлын дарааллын 5 дугаар асуудал болох Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ болон 8 дугаар асуудал болох Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/-ийн хэлэлцүүлгийг хууль санаачлагчид нэгтгэн явуулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан ажлын хэсгийн зүгээс ажлын 2 өдрөөр хойшлуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлуудыг хойшлуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар мэдэгдэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Наранбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг асуудлыг хаалттай горимоор хэлэлцэхийг мэдэгдэж, хуралдаан 15 цаг 56 минутаас 16 цаг 01 минутад хаалттай горимд шилжив.

Гурав.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын удирдлагын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга Н.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Үүрийнтуяа, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 2, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Б.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жавхлан, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.1.51 дэх заалтын “гааль, татварын албаны” гэснийг “гаалийн мэдээллийн сан, татварын” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 18.1.13, 18.1.14 дэх заалтын “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталж нэмэлт, өөрчлөлт оруулсан,” гэснийг “Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцыг хэрэгжүүлэхэд ашиглах” гэж, мөн зүйлийн 6 дахь заалтын 76¹.3 дахь хэсгийн “тогтоож, татвар төлөгчид мэдээлнэ.” гэснийг “тогтооно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 6

Бүгд: 19

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “70” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, П.Ганзориг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 19 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “асуудлыг агуулсан” гэснийг хасах.

Найруулгын санал

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “, тайлбар” гэж нэмж, 6 дахь заалтын 76^{1.1} дэх хэсгийн “Гааль” гэснийг “Гаалийн байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 6

Бүгд: 19

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын удирдлагын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга Н.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, П.Сайнзориг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их

Хурлын гишүүн Х.Ганхуяг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Наранбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь заалтын “Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютер” гэснийг “Сервер, өгөгдөл хадгалах болон боловсруулах зориулалтын тоног төхөөрөмж, график болон бусад зориулалтын процессор бүхий тооцоолон бодох төхөөрөмж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.23 дахь заалтын “виртуал бүсэд бүртгүүлсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19

36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19

63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Х.Ганхуяг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж өөрчилж, мөн хэсгийн “6-10 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 15 хувиар,” гэснийг, мөн хэсгийн “200 сая” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 18
Бүгд: 19
5.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““2.5 тэрбум” гэж гэсний дараа 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, “10-ны” гэснийг “5-ны” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, “20-ны” гэснийг “05-ны” гэж,” нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “2.5 тэрбум” гэж гэсний дараа 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, “10-ны” гэснийг “5-ны” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, “20-ны” гэснийг “05-ны” гэж, нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: 6.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “22.5.4 дэх” гэсний өмнө “22.1 дэх хэсгийн “20.2.7” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын удирдлагын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга Н.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, П.Сайнзориг, Х.Булгантуяа, Б.Мөнхсоёл, Г.Ганбаатар нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Л.Мөнхбаясгалан, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Наранбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16^{1.5} дахь хэсгийн тайлбарын “Барааг” гэснийг “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан барааг” гэж өөрчилж, мөн зүйлийн 16^{1.11} дэх хэсгийн “бол тухайн албан татварын” гэсний өмнө “шийдвэр гарсан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	2
Бүгд:	19

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	11
Бүгд:	19

42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Н.Наранбаатар: 3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “400” гэснийг “1 тэрбум” гэж, “2.5” гэснийг “1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	17
Бүгд:	19

10.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.10 дахь хэсгийн “100.0 мянган америк доллароос” гэснийг “360 000 000 төгрөгөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын удирдлагын арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга Н.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Н.Наранбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “олимпын төрлийн спортын холбоо,” гэснийг “олимп, тивийн наадмын төрлийн спортын холбоо,” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Саналын томьёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг “ӨӨРЧЛӨЛТ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар нээлттэй горимоор 5 асуудал, хаалттай горимоор 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 2 цаг 21 минут үргэлжилж, 30 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
15 цаг 43 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53.3 хувьтай бүрдсэн тул 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна.

Ирсэн гишүүд Норовын Алтанхуяг, Жамбын Батсуурь, Гомбын Ганбаатар, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Ринчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Пүрэвжавын Ганзориг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Пүрэвжавын Сайнзориг, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Хассуурийн Ганхуяг, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- 1.Байнгын хорооны тогтоолын төсөл “Цаглавар батлах тухай”,
- 2.Байнгын хорооны тогтоолын төсөл “Төсвийн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 4 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Хаалттай.
- 3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.
- 4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.
- 5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.
- 6.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 2 гишүүн 2026 оны 03 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

8.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүн 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Өнөөдрийн хэлэлцэх асуудлын тов, дараалалд тусгагдсан Монгол Улсын Засгийн газраас болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсөл санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөнтэй холбогдуулан ажлын хэсгээс нэгтгэсэн төслийг гишүүдэд санал авах зорилгоор 48 цагийн хугацаа хэрэгтэй байгаа гэсэн 2 өдрийн. Дэгийн тухай хуулиараа шаардлага үүссэн болохоор Монгол Улсын Засгийн газраас болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг энэ 7 хоногийн 5 дахь өдөр хүртэл хойшлуулах горимын санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн горимын санал гаргалаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Ирцэд орсон гишүүд танхимд орж ирээрэй. Ирцэд орсон гишүүд танхимд ирье. Ирцэд орсон гишүүд танхимд орж ирье. Гишүүд, одоо санал хураалт явуулъя.

Ганхуяг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

56.3 хуваар горимын санал дэмжигдлээ. Мөнхсоёл гишүүнийг дэмжсэнд аваарай.

Нэг дэх асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль, тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын даргаас сар бүр захирамжаар батална гэж, мөн хуулийн 5.6 дахь хэсэгт энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу боловсруулсан Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан. Тогтоолын төслийг танилцуулъя. Тараасан.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? “Цаглавар батлах тухай” тогтоолын төсөлтэй тарааж өгсөн байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Санал хураалт явуулж эхэлье.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

68.8 хувиар дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын тогтоолыг хэлэлцэж дууслаа.

15.56 цаг.

Хоёр дахь асуудалдаа оръё. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хаалттай горимоор хэлэлцэнэ. Хаалттай горимд шилжүүлээрэй.

15.56 цаг.

Байнгын хорооны хуралдаан 15 цаг 56 минутаас 16 цаг 01 минутад хаалттай горимд шилжив.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн нэрс Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Рэгзэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалтын удирдлагын арга зүйн газрын дарга, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Дамдинпүрэвийн Цогтжаргал Татварын ерөнхий газрын Татварын орлого, удирдлагын хэлтсийн дарга, Нэргүйн Цолмон Гаалийн ерөнхий газрын Татвар орлогын газрын дарга.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ганхуягаар ахлуулан 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ, Алив чимээгүй байж байгаарай. Чимээгүй байж байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Бат-Эрдэнэ нар 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлого албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэж анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар дээрх татварын хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батбаяр, Батболд, Болормаа, Ганзориг, Жавхлан, Мөнхбат, Пунсалмаа, Соронзонболд, Сэддорж, Тэмүүлэн, Хосбаяр, Энхтүвшин, Энхцэцэг нар ажиллаж байна.

Ажлын хэсэг татварын хуулийн төслүүдэд туссан асуудлыг нарийвчлан судалж холбогдох судалгаа тооцоолол, мэдээлэл, татвар төлөгчдөөс болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналтай танилцсан бөгөөд хуулийн төсөлд туссан асуудлууд бүрийг нэг бүрчлэн хэлэлцэн дараах байдлаар Байнгын хороонд танилцуулж байна.

1.Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ гишүүн нараас 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд Олимп, тивийн наадмын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалтыг тусгах.

2.Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд татварын өр барагдуулах ажиллагаанд татвар төлөгчийн санхүүгийн чадамж, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй хүндрэл, эрсдэлийг харгалзан дансыг бүхэлд нь битүүмжлэх бус дансанд орох орлогын 20 хувийг дансанд нь үлдээх зохицуулалтыг 30 хувь болгож нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгах, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх

босгыг 400 сая төгрөгөөр болгон нэмэгдүүлэх зохицуулалтыг иргэн, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдээс өнгөрсөн 2 жилийн хугацаанд ирүүлсэн саналд үндэслэн хасах, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд туссан өндөр үнэлгээтэй суудлын автомашин дотор боогдуулах босго үнийг 100 мянган доллар буюу гадаад валютаар тогтоосныг төлбөр тооцоог Үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгтэй нийцүүлэх.

3.Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.26-д заасны дагуу хууль санаачлагчид нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн тул нэгтгэн хэлэлцүүлэх зэрэг асуудал болно.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн нэр, томъёог хоёрдмол утгагүй, товч тодорхой илэрхийлэх нийтлэг шаардлагын хүрээнд зарим саналыг томъёолсон болно.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэн томъёолж та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нар өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Хууль хуулиараа. Нэрээ өгөөрэй.

Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхлээр энэ Татварын ерөнхий хууль дээр уул нь орж ирэх ёстой заалт л даа энэ нэмэгдсэн өртгийн албан татвар дээр орж ирчхээд байгаад байгаа юм. Би бол энэ саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн. Тэгээд хөндөгдөөгүй заалт гээд оруулж ирээгүй байгаад байгаа юм. Яг үнэндээ энэ нэмэгдсэн өртгийн албан татвар дээр энэ татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг үзүүлэхээр ингээд нэмэгдсэн өртгийн албан татвартаа оруулаад ирчихсэн.

Гэтэл ерөнхий хууль дээрээ энэ заалт нь 53 дугаар зүйл дээр байгаа байхгүй юу татвар төлөх хугацааны хөнгөлөлт гээд. Энэ дотор юу байхгүй вэ гэвэл хууль тогтоомжийн даган мөрдөлтийн түвшин сайн буюу сайнаас дээш түвшинд байвал 1 дээр нэмэх нь 2 сар гээд ингээд 3 сарын татварынхаа өр төлөх хугацааг нь сунгаж өгнө гэдэг ийм заалт нэмэгдсэн өртгийн албан татвар дээр ороод ирчхээд байгаа юм. Тэгээд ерөнхий хуулийнхаа энэ 53 дээр орж ирэхгүй болохоор одоо ямар асуудал үүсгэх гээд байна вэ гэхээр зэрэг бараагаа хилээр оруулаад ирчихсэн ингээд 3 сарын хугацаагаар ө төлөх ёстой өрөө хойшлуулаад сунгах эрхээ авчхаж байгаа юм хуулийн дагуу.

Гэхдээ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ч гэдэг юм уу, суутган нэг гэдэг юм уу бусад төрлийнхөө татвараар өртэй байвал нөгөө хуулийн Татварын ерөнхий хуулийнхаа 63 дээр байдаг татварын өрийг үл маргах журмаар гаргуулах гэсэн энэ журмынхаа дагуу дансыг нь битүүмжлэх, хаах, хөрөнгийг нь битүүмжлэх, хаах гэсэн энэ арга хэмжээнүүд чинь яваад эхэлнэ. Яваад эхэлнэ. Худалдаа аж үйлдвэрийн танхимынхан ярьж л байсан л даа энэ дээр. Бараагаа зараагүй байхад НӨАТ-ын татвар төлөөд байна гэдэг ийм зүйл ярьж байсан. Тэгэнгүүт нь яг энэ зүйлд нь холбоотойгоор нэмэгдсэн өртгийн албан татвар дээр нь энэ хуулийн заалтыг нь оруулаад ирчхэж байгаа юм.

Гэтэл бодит амьдрал дээр энэ чинь ямар ч хэрэгжихгүй ийм заалт болчихоод байна шүү дээ. Ерөнхий хуулийнхаа 53 дээр та нар энийгээ оруулж ирж өгөхгүй бол НӨАТ-аар хэчнээн өртэй байгаад НӨАТ-ынхаа хуулийн энэ хугацаат, татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдэлсэн ч гэсэн бусад төрлийн татвараараа татварын албан дээр өртэй байвал ялгаа байхгүй нөгөө үл маргах журмаар, гаргуулах журмаараа дансыг нь хаадаг процесс эхэлдгээрээ эхлээд л явна. Хууль нь тийм. Тэгээд энийг энэ Татварын ерөнхий хууль дээр яагаад оруулж ирж өгөөгүй юм бэ? Анхнаасаа хууль бичихдээ энэ дээрээ яагаад анхаараагүй юм бэ гэдэг ийм асуудал байгаа юм. Энэ дээр хариулт авъя.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Заяабал гишүүнээс ирсэн санал бол аж ахуйн нэгж дээр 1, 2, 3, 4 санал ирсэн. НӨАТ дээр, хувь хүний орлогын баримт дээр 1, өөр санал бол ирээгүй байна шүү. Татварын ерөнхий хууль дээр танаас санал ирээгүй байна албан ёсоор. Хэрвээ бичгээр хүргүүлсэн бол ажлын хэсгээс гадна яг Байнгын хороон дээр бол таны ирсэн санал хураагдах ёстой. Хэлэлцэгдэнэ гэсэн үг. Хэрвээ та үнэхээрийн санал гаргасан бол. Чимидсүрэн нэмээд хариулчих.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг индрийн микрофон дээр хариулна.

Ч.Чимидсүрэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр НӨАТ-ын хууль дээр тусгагдчихсан хугацааны хойшлуулж байгаа энэ зохицуулалт бол

хэлэлцүүлгийн шатад энэ татвар төлөгчдөөс бид нар энэ хил гааль дээр НӨАТ-ыг нь төлчхөөд оруулж ирэх нь өөр бараа, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх, худалдаалахаас хийгдээгүй үед ингээд зээл авах ч юм уу энэ хэлбэрээр яваад байна гэдэг ийм асуудал яригдсан. Тэгээд бидний судалгаагаар ч гэсэн ер нь аж ахуйн нэгж байгууллагууд дээр энэ эргэлтийн хөрөнгө сул байна зээлээр энэ асуудлуудаа татвараа төлж байна гэсэн ийм асуудлууд үүсээд тэрэнд нь боломж олгох зорилгоор хил гааль дээр НӨАТ-ыг нь төлөх биш 2 ч сар хүртэл хугацаагаар хойшлуулах ийм боломжийг хаасан учраас энэ төрлийн хуульд нь хугацааг нь энэ хойшлуулах зохицуулалтыг авч үзсэн.

Ерөнхий хуулийн 53 бол бүх төрлийн татвар дээр хугацаандаа төлөөгүй татвар дээр нь 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах тийм зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ бол бид нар зөвхөн НӨАТ-д нь зориулаад тэр эргэлтийн хөрөнгө, санхүүжилтийн заавал зээл авах буюу ийм хүндрэлээс нь гаргах зорилгоор л энэ хугацааны төлөх хугацааг нь хойшлуулж байгаа ийм зохицуулалтаар орсон агуулга байгаа.

Н.Наранбаатар: Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Чимидсүрэн гишүүн ээ тэгэхдээ та бид хоёр хоёулаа энийг сайн мэдэх ёстой л 2 хүн шүү дээ. Та битгий ингээд худлаа хариулаад бай л даа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр өртэй компани гааль дээр юм оруулаад ирчихлээ 3 сарын хугацаа төлөх оруулж ирсэн бараан дээрээ 3 сарын хугацааны дараа төлөх эрхээ авлаа. Аж ахуйн нэгж дээрээ аж ахуйн нэгжийнхээ татварынхаа төрөл дээр ч гэдэг юм уу, суутган нэг төрөл дээрээ ч гэдэг юм уу өртэй байгаа компанийг татварын албаныхан тэр чинь хуулиа биелүүлэх ёстой шүү дээ. Төрийн алба хуулиа л биелүүлнэ. Хүссэн, хүсээгүй дансыг нь хаагаад л явна.

Тэгээд бараа оруулж ирсэн, хилээр бараа оруулж ирсэн гэдгээрээ бусад төрлийн татвараараа өртэй байгаа компанийн дансыг нээнэ гэсэн үг юм уу? Татварын алба энийг хийж чадахгүй шүү дээ та бид 2 энийг хамгийн сайн мэдэж байгаа шүү дээ. Доор энэ хуулийг биелүүлээд ажиллаж байгаа энэ байцаагчид, албаны чинь нэгж, ажилчид яг энэ хуулиас чинь болоод яг энэ хуулийн хийдлээс чинь болоод асуудалд орох нь байна шүү дээ. Дараа нь нөгөө Эрүүгийн хуулийн 22.1-ээр давуу эрх энээ тэрээ гээд асуудал үүсвэл яах юм бэ? Зүв зүгээр төрийн алба хийж байгаад ингээд гэмт хэрэгтэн болох ийм асуудлыг энэ хуулиараа та нар оруулж ирж байна шүү дээ Чимидсүрэн гишүүн, даргаа. Та энэ дээрээ тодорхой хариулт өг дөө. Яг энэ тодорхой. Хууль хэрэгжилт дээрээ энэ чинь яг яах юм бэ?

Н.Наранбаатар: Чимэдсүрэн.

Ч.Чимидсүрэн: Харин тэрийг л тайлбарлаад байгаа юм. Энэ бол зөвхөн НӨАТ дээр НӨАТ дээр шууд гаалиа төл НӨАТ-аа төлчхөөд бараагаа ав гэдэг энэ асуудлыг л НӨАТ-ын хувьд, санхүүгийн хувьд боломжгүй байгаа бол зөвхөн НӨАТ дээр чинь 2 хүртэл хугацааны төлөлтийг хойшлуул хийе гэдэг асуудал ярьж байгаа байхгүй юу. Энэ дээр бусад төрлийн татварын асуудал нь яригдаагүй. Тийм учраас бид нар Ерөнхий хуульд оролгүй НӨАТ-ын хуульд энэ зохицуулалтыг нь хийсэн байгаа юм.

Тэгэхээр бусад төрлийн татвар дээрээ өртэй байсан ч гэсэн НӨАТ-т нь дахиж тэр 2 сарын хугацааны боломжийг олгож байгаа л ийм л агуулгатай заалт байхгүй юу.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя.

Х.Ганхуяг: Яг Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйл өргөн барьсан төсөл хөндөгдөөгүй юм байна. Харин тийм тэгээд хөндөгдөөгүй болохоор тэн дээр ямар нэгэн зарчмын зөрүүтэй санал гаргах боломжгүй.

2 дугаарт нөгөө татварын өртэй компаниуд дээр бол энэ шинэ орж Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр бол 80, 20-оор нөгөө татвар юу билээ данснаас нь мөнгө суутгаж явахаар өргөн баригдсан байгаа. Нэг ёсондоо дансыг нь хаахгүйгээр орж ирсэн мөнгөнөөс нь ингээд 20 хувь нь үлдээгээд 80 хувь нь шууд суутгаж явахаар зохицуулалт орсон байгаа.

Гуравт бол яг НӨАТ-тай холбоотой хэсэг дээр бол ер нь бол өнгөрсөн 2 жилийн хугацаанд яг хэлэлцүүлэг хийхэд явахад бол хамгийн том хүндрэл бол нөгөө НӨАТ-ын өрөнд ордог эргэлтийн хөрөнгийн дутагдлаа бий болгодог. Тэрнээс болж банк, банк бус, ломбардаас ингээд зээл авдаг гэсэн асуудал хамгийн их яригдсан асуудал. Тэгээд тийм учраас тухайн үед бол татварын ажлын хэсэг бол энэ саналыг үзсэн аз болж, аз болсон гэх юм уу юу гэх юм энэ Засгийн газар энэ хуулийн төсөлдөө оруулсан байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Асуултаа асуух уу тээ? Энэ 6.1.51 дээр хууль даган мөрдөлтийн түвшин гэдэг дээр энэ гаальтай холбоотой мэдээ, мэдээллийн сангийн асуудал бас орж ирж байна л даа. Гаалийн мэдээллийн сан, татварын бүртгэлийн санг нэгтгэж байна гээд 19 онд нэг журам гаргасан гээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр асуудал үүссэнийг та бид бүгдээрээ мэдэж байгаа. Нэг программ орууллаа гэнгүүтээ гаалийн мэдээллийн сан дээр шууд автоматаар тэр татвар руу татаж оруулаад АМНАТ-ыг яадаг вэ гэхээр ашигт малтмалын ашигтай хэсгээс нь үл хамаараад тэн дотор байгаа элемент бүрийнх нь хувиар тооцоод эхэлсэн. Ингэснээсээ болоод энэ Ашигтын хуулиар нэг тусдаа нэг татварын асуудал яваад Татварын ерөнхий хууль болон татварын асуудлууд нь тусдаа хуулиар яваад хоорондоо ойлголцдоггүй нэг ийм зөрүүтэй асуудал өнөөдрийг хүртэл явж байна.

Одоо яг энэ Ашигтын хууль явж байгаа үед Татварын ерөнхий хуультайгаа уялдуулах асуудлаа ер нь харж үзэж болохгүй байсан юм уу? Эрдэнэт үйлдвэр АМНАТ дээр төлбөр жишээлбэл, хорт элемент, торгуульт элементүүдээсээ хог хаягдлаасаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөд энэ бол өнөөдөр дэлхийд хаана ч байхгүй жишиг явж байгаа шүү дээ. Тэгээд шүүхдээд Татварын ерөнхий газартайгаа шүүхдээд татвар дээрээ Ерөнхий газартайгаа шүүгдсэн. Дээд шүүх хүртлээ яваад тэр дээрээ ялчихсан. Эргээд энэ нь бараг юу гэдэг юм бусад гаднын хөрөнгө оруулалттай компаниудад нөлөөлөх гээд байна гэдэг зүйл яриад юмаа тат аа энэ тэр гээд төрийн өмчийн компаниуд руугаа хүртэл хандаж байсан асуудлууд үүсэж байсан. Тэгээд энд зохицуулагдаж чадахгүй байсан энэ харилцаануудаа оруулж ирэхгүй байсан юм уу? Одоо энэ ашигтын хууль явж байгаа үед яах юм? Тэгээд Зэсийн АМНАТ-ыг хойшлуулъя гээд л хойшлуулчих юм уу? Энэ ерөнхий хуулиа хэлэлцэж байгаа үедээ өөрчлөлт оруулах боломж гарсан үедээ энэ уялдаа холбоогоо хангах юмаа хийхгүй байсан юм уу? Яг ямар зохицуулалтууд нь ороод ямар зохицуулалтуудыг гадуур үлдээгээд байгаа юм бэ?

Шаардлагатай зохицуулалтууд чинь нэгдэж орж ирэх ёсгүй байсан юм уу? Би ийм л зүйлийг асуумаар байна. Надад энэ АМНАТ-аар тодорхой хариулт өгмөөр байна.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч.

Х.Ганхуяг: Дэгийн тухай хуулиар, Хууль тогтоомжийн хуулиар бол бид нар бол яг өргөн баригдсан төсөл хөндөгдсөн заалтуудын хэмжээнд л бид нар юунуудаа хийдэг шүү дээ. Тэрнээс биш бол өргөн баригдаагүй асуудал дээр тэр юунуудыг нэмж оруулах ямар ч боломж байхгүй гэсэн үг. АМНАТ-тай холбоотой асуудлаар. Саяын ярьж байгаа тэр хууль даган мөрдөлтийн түвшин гэдэг бол саяын ярьж байгаа тэр НӨАТ-ыг нөгөө хугацаа өгөх тэр асуудал дээр нь анх удаагаа бид нар энэ сайн, дунд, муу гээд ангиллуудыг хийгээд явна гэсэн үг. Магадгүй энэ удаад бол НӨАТ гэж яваад дараад нь яадаг юм тэр компаниудын татвараа сайн төлдөг байдлаар нь бид нар дараа дараагийн урамшууллын юмнуудыг нь бид нар дараа дараагийн урамшууллын юмнуудыг нэвтрүүлэх боломжууд бол бүрдэн гэсэн үг.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Хууль даган мөрдөлтийн түвшин гэдэг тодорхойлолтыг нэмж оруулаад энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад гаалийн байгууллагын мэдээллийн сан гэж оруулсан байна л даа. Гаалийн мэдээллийн сан гэж нэмж оруулсан байна шүү дээ. Тэгээд би гаалийн мэдээллийн сан, татварын мэдээллийн сангийн хоорондын асуудлыг л яриад байгаа юм л даа. Тэгэхээр би бол өргөн баригдсан хүрээнд асуудлыг ухаж ойлгоод байна л гэж бодож байна. Тэгэхээр энэ асуудал дээрээ гаалийн мэдээллийн сан, татварын мэдээллийн сан хоёрын хоорондын уялдаа холбоог хангаж байна гэдэг үндэслэлээр л ийм зүйл ороод ирсэн шүү дээ журмаар зохицуулаад л. Энэ дээр Татварын ерөнхий газар ямар байр суурьтай байгаа юм. Ерөнхий газраас сонсьё.

Н.Наранбаатар: Индрийн микрофон дээр ажлын хэсгээс хариулъя.

Б.Цогтнاران: Татварын ерөнхий газар Цогтнاران. Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол Татварын хууль даган мөрдөлтийн гэсэн ийм ойлголт оруулж ирж, татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг хойшлуулахаар ингэж хуулийн төсөл оруулж ирж байгаа.

Хуулийн төсөл батлагдсан тохиолдолд Сангийн сайдын журмаар татвар төлөгчдийг хууль тогтоомж мөрдөлтийн түвшнээр нь ангилах ийм зохицуулалтууд орж ирж байгаа.

Эхний байдлаар бол Гаалийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрууд харилцан мэдээллүүдээ солилцоод нэгтгэх байдлаар ингээд ажлыг зохион байгуулаад эхлүүлээд явж байгаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууя. Санал хэлье.

Г.Ганбаатар: Энэ ажлын хэсгээс бэлтгэсэн танилцуулгатай холбоотой би 2 асуулт, үгүй ээ 1 асуулт, 1 тодруулга авъя гэж бодлоо. Сая ажлын хэсгийн дарга Ганхуяг дарга энэ Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд энэ татварын өр барагдуулах ажиллагаанд татвар төлөгчдийн нөгөө санхүүгийн чадамж, бизнесийн үйл ажиллагаанд учирч байгаа энэ эрсдэлээ

харгалзаад 80/20 гэх шиг боллоо. 80/20 гэхдээ энэ чинь мэдээлэл дотор чинь 10 хувь нэмэгдэх тухай зохицуулалт орж ирсэн тухай байна. Өөрөөр хэлбэл, 30 хувь болох энэ талаар 1 дүгээрт тодруулга авъя. 80/20 гэдэг чинь хатуу юу байгаа юм уу? Энийг яагаад бүүр тийм хатуу 80/20 гээд яриад байгаа юм бол гэдэг асуудал.

2 дугаарт нь тэр нэг аж ахуйн нэгж байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд олимп тив энэ олон төрлийн спортын холбоо, мэргэжлийн баг, тамирчдад дасгалжуулагч олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг албан татвараас хасаж хөнгөлөх тухай зохицуулалт байна шүү дээ тээ энэ дээр энэ яах вэ хэлэлцүүлгийн явцад өөрчлөгдөж магадгүй. Одоо бид нар чинь ерөөсөө бүх юмны үнэ өсчихсөн тухай ялангуяа энэ мах захны үнэ ч ерөөсөө бараг 50 хувьд өсчхөөд байгаа юм уу. Үгүй тэгээд энэнтэй энэ хөдөө аж ахуйн орон манайх. Энэ хөдөө аж ахуйн салбарт энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа ялангуяа Улаанбаатар хотыг тойрсон энэ суурин газруудыг тойрсон хөдөө аж ахуй, сүү, махны чиглэлээр яг энэ чиглэлийн зохицуулалт оруулж ирэх боломжтой юу? Монгол зохицуулалт. Тэгэхгүй бол үеийн үед л бид нар нэг ийм юм ярих нь байна шүү дээ. Энэ чинь нөгөө Улаанбаатар хотын захирагч төдийгүй Засгийн газраа огцруулдаг хэлбэр рүү орох гээд байна шүү дээ. Манай хөдөө аж ахуй бол эмзэг шүү. Байгаль цаг уурын хувьд ч тэр ер нь энэ чиглэлийн нэг татаас, зохицуулалт энэ юугаар нь ороод ирвэл. Тамирчдад санхүүгийн дэмжлэг олгож болоод байгаа юм бол хөдөө аж ахуйн салбартаа дэмжлэг үзүүлэх энэ Татварын ерөнхий хуульд ийм зохицуулалт оруулж ирж болохгүй байна уу? Энд хэн хариулах вэ?

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Ганхуяг: Засгийн газраас өргөн барьсан төсөлд бол Татварын ерөнхий хууль дээр энэ татварын өртөг компаниудын дансыг шууд нөгөө бүдүүлгээр ингээд хаагаад орж ирсэн мөнгийг нь бүгдийг нь авдаг байсныг халаад нөгөө олон улсын практикт байдгаар нөгөө тодорхой хэмжээг нь үлдээдэг нэг ёсондоо компанийг дампууруулахгүйгээр, цалингаа өгөх боломжийг нь олгохоор тэгээд 20 хувийг нь үлдээг 80 хувийг нь суутгадаг байхаар өргөн барьсан төслийг бас ажлын хэсэг дээр ажиллаад тэрийг нь 70/30 болгохоор санал хураалт хийгээд 70/30 гэдгээр ажлын хэсгээс санал нь орж ирж байгаа. Тэрнээс илүү болчихоор нөгөө төсөв бүрдүүлэлт гээд нөгөө олон асуудлууд бас сөрөг үр дагаврууд гарахаар юм шиг байгаад байна. Яах вэ магадгүй эхний ээлжид бид нар 70/30-аараа явж байгаад тэр асуудал ингээд гайгүй яваад байвал магадгүй тэрийг нь дараад нь 60/40 болгодог ч юм уу иймэрхүү байдлаар дараа дараагийн удаа бол хийж болохоор юм шиг харагдаж байгаа юм.

Энэ олимп, тивийн наадамтай холбоотой татварын хөнгөлөлтийн асуудал байна. Энэ бол юу шүү нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа хөрөнгө оруулалт, энэ хандив, тусламжийг татварын 1 хувиар, борлуулалтын орлогын 1 хувиар буюу энэ юу үзүүлж болно гэдэг 22.9 байгаа Аж ахуйн нэгжийн орлогын татварын. Тэн дээр Сайнзориг гишүүн болон Бат-Эрдэнэ гишүүн нар тэр и-спорттой холбоотой асуудлыг тийшээ оруулмаар байна гэсэн байдлаар хуулийн төсөл өргөн барьсан байдаг юм.

Тэр нь болохоор Биеийн тамир спортын тухай хуулийн 10.10.1.1-д заасан төрлүүдийг тэр хөнгөлөлтөд хамруулмаар байна гэсэн тийм хуулийн төсөл байгаа. Үзэл баримтлал нь. Тэгээд тэр нь болохоор яадаг вэ гэхээр тухайн Соёл, спорт, аялал, жуулчлалын сайдын тушаалаар тэр төрлүүдийг тодорхой болгодог. Өнөөдрийн байдлаар бол 26 төрлийн спорт байгаа.

Тэгэхээр энийг хязгаарлах үүднээс олимп, тивийн наадам гэж оруулж өгч байгаа юм. Тэгэхгүй бол сайдын тушаал гэдэг маань маргааш 30 болж болно, нөгөөдөр 40 болж болно. Тийм утгагүй юм болох болохоор бид нар олимпын болон тивийн төрлийн спортуудыг оруулснаар тэр үзэл баримтлалд нийцүүлээд энэ саналыг оруулж байгаа гэсэн үг.

Яг хөдөө аж ахуйн салбартай холбоотойгоор нөгөө 22.9 дээр хөдөө аж ахуйн салбартай холбоотой юм байдаггүй юм. Тэн дээр чинь бол соёл байдаг юм, спорт байдаг юм. Нийгмийн нийгэм хамгааллын чиглэлийн юм асуудлууд байдаг юм. Байгаль орчны чиглэлийн асуудлууд байдаг юм. Яг хөдөө аж ахуйн чиглэлтэй холбоотой асуудал дээр 1 хувийн татварын хөнгөлөлт эдлэхээр нийгмийн хариуцлагын хүрээнд хөндөгдсөн заалт байдаг бөгөөд мөн гишүүдийн өргөн барьсан төсөл дээр тэрийг хөндсөн бас заалт байхгүй байгаад байгаа юм. Тийм.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Би протоколд үлдээх гээд байна л даа. Яах вэ нийгмийн хариуцлагын хүрээнд. Ингээд тэр и-спорт ч гэнэ үү, олимп тив ч гэнэ үү амжилт гаргаад тэр хөрөнгө оруулаад явбал 1 хувийн татварын хөнгөлөлт гээд байна л даа. Бид нар ингээд Улаанбаатар төв суурин газрынхаа хүнсний хангамжийг шийдэж чадахгүй байж байж том том и-спорт яриад л тэгээд л 1 хувийн татвар. Хөдөө аж ахуйн салбар ялангуяа Улаанбаатар, төв, Эрдэнэт, Дархан ч юм уу ер нь энэ хөдөө аж ахуйн салбарт нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулалт хийсэн компаниуд дээр энэ 1 хувийн чинь хөнгөлөлт, урамшуулал бид нар хэлэлцээд ярьж оруулж болохгүй юу? Тэгэх юм бол энэ чинь яваандаа энэ хэл ам болоод байгаа мах, сүүний үнэ, яваандаа энэ өргөн хүнсний өргөн хэрэглээний барааны үнийг шийдвэрлэхэд их дорвитой заалт болохгүй юм уу л гээд асуугаад байгаа юм л даа. Тийм заалт байхгүй гээд байх юм. Тэгээд нэмээд оруулаад Татварынхаа ерөнхий хуульд өөрчлөлт оруулаад энэ чиглэлээр бодох юм байна уу л гээд байгаа юм л даа.

Би Хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хороон дээр бол байнга л ярьдаг л сэдэв. Тэгээд төсвийнхөн дээр бас энийг энийг нэг бодолцоод өгөөч гээд байгаа юм.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Ганхуяг: Бид нар бол ялт ч үгүй л бол хөдөө аж ахуйн салбарыг бол анхаарах цаг болсон. Мал аж ахуйн салбарыг ч анхаарах хэрэгтэй. Нэн ялангуяа өнөөдрийн энэ геополитикийн тодорхой бус нөхцөл байдалд бас орсон. Евроазийн хэлэлцээрийг хийсэн энэ асуудлууд юуг нь ярьж ингээд бид нарын нөгөө үндэсний сөрөн тэсвэрлэх чадварыг бол байнга бодож байх ёстой, сайжруулж байх ёстой. Тэгээд магадгүй таны санал та өөрийнхөө саналаар магадгүй энэ чиглэлээр 22.9-ийг хөндсөн байдлаар хуулийн төсөл өргөн барьж болно. Тэр бол ямар ч асуудал байхгүй болов уу гэж харж байна. Баярлалаа. Яг өнөөдрийн өргөн барьчихсан байгаа хэмжээнд болохоор тэрийг хөндөх боломжгүй байгаад байгаа юм.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 7 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.1.51 дэх заалтын “гааль, татварын албаны” гэснийг “гаалийн мэдээллийн сан, татварын” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 18.1.13.3, 18.1.14 дэх заалтын “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталж нэмэлт, өөрчлөлт оруулсан,” гэснийг “Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцыг хэрэгжүүлэхэд ашиглах” гэж, мөн зүйлийн 6 дахь заалтын 76-гийн штрих 3 дахь хэсгийн “тогтоож, татвар төлөгчид мэдээлнэ.” гэснийг тогтооно гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68.4 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн 80 гэснийг 70 гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ зүйл дээр дараах санал давхардаж ирсэн байна. Энэ дэгийн хуулийн тухай танилцуулж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “50” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзориг, Жаргалан. Ажлын хэсгийн 2 дахь саналтай давхардсан. Санал хураалт.

52.6 хувиар. Ганзориг гишүүнийг дэмжсэнээр протоколд аваарай дэмжигдлээ. Батболд гишүүнийг дэмжсэнээр авъя. Ганзориг гишүүнийг авчихсан.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна. Санал хураалт. Санал байхгүй юм байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би яах вэ асуулт гэхээсээ энэ Монголын ноос, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооноос бас энэ Татварын ерөнхий хууль болон НӨАТ-ын хуультай холбоотойгоор ийм байр сууриуд илэрхийлээд байгааг би бас энд протоколд үлдээчихье гэж бодож байна.

Ерөнхийдөө өнөөдрийн явж байгаа энэ асуудлаар Малчны тухай хууль, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хууль зэргийг дагалдуулж боловсруулаад гарсан татварын өөрчлөлтөөр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт ороод энэ үйлдвэрлэгч буюу бүтээгдэхүүнээ бэлдэж байгаа хүмүүс нь зөвхөн малчдын хоршооноос авсан тохиолдолд бас асуудал нэг өөрөөр, хувь хүн гэдгийг нь хассанаасаа болоод өмнөөс нь НӨАТ төлөгч болчихоод ийм зүйлүүд байгаа. Тэгээд гарч байгаа бүтээгдэхүүн болоод үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгөд орох ёстой хөрөнгө нь энэ өмнөөс нь татвар төлөх байдал руу ингээд орчихоод байгаа. Энэ асуудлыг цаашдаа ер нь нэг бас Улсын Их Хурал дээр анхаарч өгөөч гэдэг зүйлүүдийг л хэлээд байгаа юм.

Энэ нь өөрөө энэ нөгөө манай жижиг, дунд үйлдвэрлэгч буюу энэ малчдын түүхий эдийг л бүтээгдэхүүн болгож байгаа хүмүүст өрсөлдөх чадварт бас нөлөөлөөд байгаа юм билээ. Тэгээд энэ цаашдаа энэ татварын асуудлыг зөв болгож өгөөч ээ, уламжилж өгөөч ээ гэдэг зүйл байгаа юм. Энийг ингээд татварын ажлын хэсгийнхэнд хэлчихье.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ төслийн 3 гээд энэ одоо энэ санал хураалт болон дараагийн найруулгын санал хураалт хоёрыг нэгтгээд 1 зүйл, заалт болгоод найруулгын санал болгохгүй. Энэ бол бас нэг найруулгын саналыг бас тусад нь гаргаад яачихжээ даргаа. Нэгтгээд санал хураачихъя. Бас 3, 1, 2-ыг.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс бэлтгэсэн саналаар санал хураалт явуулна. Найруулгын санал.

Төслийн 4 төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “70” гэж өөрчлөх, Төслийн 4 дүгээр зүйлийн “асуудлыг агуулсан” гэснийг хасах. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “тайлбар” гэж нэмж, 6 дахь заалтын 76-гийн штрих 1 дэх хэсгийн “гааль” гэснийг “гаалийн байгууллага” гэж өөрчлөх.

2 нь бол биш юм байна. 2-ыг хасаад 3, 4 тийм найруулгын санал. Дахиж уншъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн “асуудлыг агуулсан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Найруулгын санал

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “, тайлбар” гэж нэмэх, 6 дахь заалтын 76-гийн штрих 1 дэх хэсгийн “Гааль” гэснийг “Гаалийн байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68.4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганзориг гишүүн танилцуулна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

16.39 цаг.

Дөрөв дэх асуудал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийн төсөл 5 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу.

Алга байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн саналаар санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь заалтын “Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютер” гэснийг “Сервер, өгөгдөл хадгалах болон боловсруулах зориулалтын тоног төхөөрөмж, график болон бусад зориулалтын процессор бүхий тооцоолон бодох төхөөрөмж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал. Хураалтад бэлтгэе. Ажлын хэсгийн саналыг. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. 11 гишүүн бэлтгэсэн байна.

Дэмжье гэсэн томъёолол томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ. Дараагийн санал.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.23 дахь заалтын “виртуал бүсэд бүртгүүлсэн” гэснийг хасах. Саналын томъёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн нэмэлт, өөрчлөлт биш үү?

2 дээр санал хураалт явуулна. Дахиад уншиж танилцуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.23 дахь заалтын “виртуал бүсэд” гэснийг хасах. санал хураалт.

68.4 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Заяабал гишүүн.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхлээр энэ төслийн 2 дугаар зүйл дээр нэг ийм юм орж ирж байгаа юм. Татварын хувь, хэмжээ нөгөө шатлалын асуудал орж ирж байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл хамгийн гол нь энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих жижиг, дунд үйлдвэрлэлийг тэлэх ийм бодлогын хүрээнд энэ шатлал ер нь явдаг л даа. Жижиг дундуудыгаа ер нь дэмжих үүднээс энэ шатлалын арга хэмжээ орж ирж байгаа юм.

Гэтэл энэ шатлалаар орж ирэхдээ энэ нойлоос 6 тэрбум төгрөг байвал 10 хувиар, 6-10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байвал 15 хувиар, 10

тэрбумаас дээш байвал ингээд 25 хувиар гэсэн ийм 3 шат л орж ирээд байгаа юм. Тэгээд миний хувьд бол энэ 6-10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байвал гэсэн ийм дундын шатлал шаардлагатай юм уу гэдэг ийм асуулт л яваад байгаа юм. Тэн дээр би ажлын хэсэгт бас саналаа гаргаж өгсөн. Тэгээд уг санал дэмжигдээгүй байна лээ. Тэгээд энэ дээр би тодруулаад бас ажлын хэсгээс асуумаар байна. 0-6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд ер нь хэд байгаа юм? 6-10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд хэд байгаа юм? 10-аас дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд хэд байгаа юм? Аль нь том юм? Нөгөө жижиг, дундуудыгаа дэмжиж байгаа бодлого чинь яг энэнтэй нийцэж байгаа юм уу гэсэн ийм асуултыг асуумаар байна.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг.

Х.Ганхуяг: Жижиг, дундыгаа дэмжих зорилгоор бол бид нар 2.5-ыг хялбаршуулсан байдлаар хийхээр энэ хуулийн зохицуулалт бол өр өргөн баригдсан. 2.1 байсан нь 1 тэрбум байсныг 2.5 болгож байгаа. Тэгээд тэрнийхээ 90 хувь нь буцаалтаар олгохоор зохицуулагдсан байгаа 1 дүгээр асуудал. Үгүй. яах вэ 2 дугаар, энэ чинь цөмөөрөө хуулиа нэг том тийм хуулиа нэг зүйлээр харахгүй бол нэг зүйл, заалтыг, энэ хууль гэдэг маань Аж ахуйн нэгжийн хууль гэнэ үү Аж ахуйн нэгжийн л хуулийг л би энэ хүрээнд яригдаж байна тайлбар өгч байгаа гэсэн үг.

6-10 тэрбумын хооронд Засгийн газраас яагаад энэ зүйлийг өргөн мэдүүлсэн бэ гэдгийг тодруулахад бол үндсэндээ бол энэ дээр бол 300 гаруй компани байна гэсэн. 300 гаруй компани. Тэр 300 гаруй компани нь ихэнхдээ уул уурхайн бус чиглэлийн компаниуд байна гээд байгаа юм. Тэгээд иргэд, компаниуд нь ямар хүсэл гаргаад байна гэхээр бид нар ерөөсөө хуримтлалтай болж чадахгүй байна. Яг уул уурхайн компаниа адилхан 25 хувийн татвар төлөөд эхлэхээр эргээгээд ерөөсөө ингээд хямралаас хямралын хооронд явдаг, тэгээд хамаг юмаа татвар төлдөг, нэг бол компаниа жижгэрүүлэх шаардлага үүсдэг. Жижгэрүүлчихээр эргээд санхүүжилт олж авах ч гэдэг юм уу нөгөө бусад асуудлууд нь юу улам хүндрээд байна. Дээрээс нь захиргааны зардал нэмэгдээд байна гэдэг асуудлуудыг аж ахуйн нэгжүүдийн зүгээс яригдсан байна.

Тийм болохоор энэ 3 дундуур нь 6-10 тэрбумын хооронд 15 хувийн шатлал оруулж ирсэн 1 дүгээр шалтгаа.

2 дугаар шалтгаан бол 10, аж ахуйн нэгжийн орлогын татвар бол 10 хувьтай байгаа. Тэгээд 6-аас дээш тэрбум болонгуут шууд 25 хувиар орчихдог. Шууд 25 руу орохоор сөрөг үр дагавар нь юу гарч байна гэхээр ерөөсөө л хиймэл баахан компани нөгөө шинээр компаниуд үүсгээд явж байдаг. Тэгэхээр яг бодит нөгөө компаниуд нь ингээд томордоггүй. Нөгөө асуудлууд нь яаж байна гэхээр баахан компаниудаа жижиглээд л зүгээр л нэг тайлангийн л баахан компаниуд бий болгоод байгаа байхгүй юу. Асуудал нь ерөөсөө тэндээ байгаад байгаа юм. Тэгэхээр би цөмөөрөө нэг тайлантай байя, бас эргээгээд нөгөө уул уурхайн бус компаниудаа дэмжье гэсэн үүднээс энэ 6-10-ын хооронд 15 хувь гэдэг шатлалыг оруулж байсан байгаа юм.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг хариулна нэмж. Сайнзориг гишүүнийг асуултын жагсаалтад оруулаарай.

Ч.Чимидсүрэн: Нэмэлт хариулт өгье. 6 тэрбум хүртэлх ашигтай гэдэг ангилалд бол 181 мянган 404 аж ахуйн нэгж энэ 25 оны тоо статистикаар байна. 6-10 тэрбумын ашигтайд нь бол 338 аж ахуйн нэгж, 10 тэрбумаас дээшхэд нь бол 260 компани, 280 компани. Ингээд нийт 620 орчим компани бол 6 тэрбумаас дээш ашигтай ажилласан байгаа.

Тэгээд түрүүний үндэслэлийг бол үндсэндээ Ганхуяг гишүүн хэллээ. Өмнө нь бид нар 6 тэрбумын босго бол бас 3 тэрбумтай байсныг 20 оноос бол ингээд 6 тэрбумтай болгосон. Тэгээд аж ахуйн нэгжүүд, томоохон аж ахуйн нэгжүүд нь бол энэ 10-аас, 6 тэрбумаас дээшээ 10 хувиар авч байснаа шууд 25 болох нь бол хэт огцом байна гэдгийг хэлсэн учраас тэдгээрүүдийн саналыг бол харгалзаад дундын шатлал буюу 15 хувь гэдгийг 6-10 тэрбумд гаргасан.

Нөгөө бичил, жижгийг дэмжсэн нь бол дараагийн 3 дугаар санал дээр, асуулт дээр, заалт дээр бол гарч ирэх юм байна.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би энэ ажлын хэсгээс орж ирж байгаа саналыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Зөв байх. Шатлал хоорондын гар ийм том болохоор аж ахуйн нэгжүүд, байгууллагууд томрох биш улам жижгэрч байгаа юм. Энэ нь өөрөө тендерт ч орж чадахгүй байгаа. Тэгээд Монгол улс чинь бас нэг хөгжиж байна шүү дээ. Томхон тендер явуулъя гэхээр хэт жижиглээд байхаар захиалагчийн эрсдэлийг болоод зардлыг өсгөчхөөд байгаа юм. Тэгээд бас нэг дундаж хэмжээний юм уу гээд зарлая гэхээр бас болж өгдөггүй. Тэгээд энэ нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн яагаад борлуулалтын орлогыг нэг тооцож болно гээд ямар тэнд хуулийг нь бүүр ингээд өөрчлөлттэй биш тендерт борлуулалтын болоод бусад орлогыг ч гэсэн тооцоход ингээд жижгэрээд яваад байхаар хэцүү байгаа байхгүй юу.

Дээрээс нь энэ орон сууцын салбар дээр энэ жижигрэлтээс болоод явж байна. Энэ 25 хувийн татвар төлөхгүй учраас энэ зарим томоохон компаниуд чинь яг бодит байдал дээрээ 70-80 компани болоод задарчихсан. Яг энэ схемээр нь бас барилгын компаниуд бас дуурайдаг. Иргэд нэг оффис дотор л баахан компаниудтай зурж байна гэдгээ ойлгодоггүй. Зураад байдаг. Дараа нь барилга бол шал өөр компани дээрээ байдаг. Эрсдээд ирэхээр яг нөгөө үндсэндээ цаасны компанитай нь зурчихсан байсныгаа ч мэдэхгүй ингээд маш их хэмжээний орон сууц захиалгын энэ шийдэгдэхгүй байгаа буюу иргэдээс бас мөнгийг нь аваад эргэлдүүлээд байгаа асуудлууд энэ схемээр явж байгаа юм байна лээ шүү. Тэгээд энэ нөгөө дараа нь ингээд хэрэглэгчийн эрх ашгийг бас хохироогоод байгаа ийм зүйлүүд байх юм.

2 дугаарт, энэ асуудал дээр энэ 15 хувийн гар дээр татварын тооцох орлогын хэмжээнээсээ үл хамаараад уг нь пионер бизнесүүдийг эхний 5 жил, 25 биш ийм зүйл рүү оруулж ирэх бололцоо байсан уу? Монголд анхнаасаа тэр технологи байхгүй, шинээр тодорхой салбар дээр шинэ технологи оруулж ирж байгаа энэ бизнесүүдийг бас нэг энэ дундын хувилбараар орлогоос нь үл хамаараад эхний 5 жил ч юм уу ингээд өгдөг баймаар байна. Тэгээд Монголчууд уламжлалт энэ бизнесийн тойргоосоо гармаар байгаа байхгүй юу. Шинэ бизнес буюу энэ орны ийм зүйлүүдийг чинь ингээд Сингапур энэ тэр дэмждэг юм байна лээ шүү дээ. Пионер бизнес буюу яг тухайн улс оронд байхгүй шинэ ажлын

байрыг, шинэ технологийг, шинэ салбарыг авчирч байгаа компаниудаа дэмждэг юм байна лээ. Энэ эрсдэлтэй гэдгийг нь ойлгодог юм байна лээ.

Тэгэхээр энэ зүгээр бодлогын юмнуудыг бас орлогоос нь үл хамаараад бас зөвхөн дэмжих тийм бололцоо байгаа юу үгүй юу? Ийм зүгээр нэг ийм байна. Тэгээд ер нь дэмжиж байна.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ хуулийн төслөөр нөгөө мэдээлэл технологийн компаниудыг заавал ч үгүй виртуал бүсэд бүртгүүлбэл татварын хөнгөлөлт эдэлдэг байсныг нь болиод мэдээлэл, технологийн чиглэлийн компаниудыг бас татварын хөнгөлөлт эдэлдэг байхаар мөн тэр компаниудын хэрэглэгдэхүүн болох өндөр хурдтай сервер компьютер болон бусад зүйлүүдийг гаалийн татвар эд нараас хөнгөлөх, элэгдэх хугацаа эд нарыг нь 3 жилийг нь 2 жилээр тооцох бас ийм боломжууд орж ирж байгаа.

Дээрээс нь удахгүй бас би бас Чөлөөт бүсийн тухай хууль өргөн барина. Тэр бол чөлөөт бүс бол бүхий л төрлийн татварын хөнгөлөлттэй тийм онцгой бүс байдаг. Гаалийн болон аж ахуйн нэгжийн болон бусад тэрийг бол ингээд удахгүй өргөн барина. Тэгээд тэн дээр бас Сайнзориг гишүүнээ санаачлагчаар хамтран оролцооч ээ. Таны яг санаа зовниж байгаа заавал ч үгүй газартай байж байж бид нар тэр мэдээлэл, технологийн чөлөөт бүс биш бүүр ингээд үүлэнд бид нар чөлөөт бүсийг хүртэл байгуулах боломжтой байхаар хуулийн төслийг бэлдсэн байгаа. Тэгээд тэн дээр бас санаачлагчаар оролцохыг бас хүсэж байна аа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналаар санал хураалт явуулна.

1 дэх санал нь Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Ажлын хэсэг дэмжээгүй санал. Санал хураалт. 36.8 хувиар дэмжигдсэнгүй.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж өөрчилж, мөн хэсгийн “6-10 тэрбум хүртэлх татварын албан татвар ногдуулах, тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш авсан орлогод 15 хувиар” гэснийг мөн хэсгийн “200 сая” гэснийг тус тус хасах.

Ингэнэ өмнөх Заяабал гишүүний өгсөн санал дээр үг хэлэхийн тулд горимын санал гаргаж дахиж хүчингүй болгож байгаад үг хэлэх юм байна дэгээр. Горимын санал гаргах гишүүн байна уу? Гандулам зөвлөх хууль танилцуулаадах.

Д.Гандулам: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Гишүүний асуултад ярья. Төсвийн байнгын хороо Гандулам . Өмнө тараагдсан саналууд бол ажлын хэсгийн саналууд байсан. Гишүүний санал бол Дэгийн тухай хуулийн 39.14 дээр гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль, тогтоолын төслийг яаралтай хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр ирүүлсэн байна гэсэн. Төсвийн байнгын хорооны хуралдаан 3 дахь өдөр байсан. Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр орох энэ хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийн саналыг энэ сарын 06 сарын 08-ны өдрийн 17 цагаас өмнө Төсвийн байнгын хороонд бичгээр ирүүлсэн энэ Заяабал

гишүүний санал бол, 3 санал бичгээр ирсэн байгаа. Одоо тэр санал, бичгээр ирсэн саналуудаар санал хураалт явуулж байгаа.

Н.Наранбаатар: Тэгвэл горимын санал гаргаад яачихъя л даа. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Дарга өмнөх саналыг хүчингүй болгож өгнө үү. Энэ төхөөрөмж бас улайгаад. Тэгээд хүчингүй болгоод дахин санал хураалт. Өмнөх саналыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

Н.Наранбаатар: Гишүүд анхааралтай байгаарай. Сайнзориг гишүүн сүүлийн гаргасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын санал гаргалаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалтыг дахиж явуулна.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэж санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал саналаа тайлбарлаж хэлнэ.

Б.Заяабал: Миний хувьд бол энэ 2 дугаар зүйлийг хасаад дараагийн санал нь би өөрчлөн найруулахаар ийм санал өгсөн санагдаад байна. Эхлээд энэ орж ирсэн энэ саналыг нь үүгээр нь хасъя, тэгээд томъёоллыг нь өөрчлөөд дахиад найруулаад бичье гээд ийм 2 санал өгсөн. Тэгээд тэр дараагийн саналууд нь яг өгсөн саналууд нь ингээд би тараагдах байх гэж бодсон. Ингээд тараагдаагүй байгаад байна л даа. Би Байнгын хороондоо өгчихсөн байгаад байдаг.

Яагаад хасах болсон үндэслэл гэвэл энэ шатлал хоорондын асуудал байгаад байгаа юм аа 0-6 тэрбум, 6-10 тэрбум, 10-аас дээш тэрбум төгрөгийн татвар ногдуулах орлоготой аж ахуйн нэгж байвал ийм 3 шатлалтай больё гээд. Одоогийн байгаа хуулиар бол бид нар 2 шатлалтай. 10 хувь, 25 хувийг нь ийм 2 шатлал. 1 хувийн байгаа хялбаршуулсны тэгээд 10 хувийн татвар, 25 хувийн татвар гэсэн ийм 3 шатлалтай бид нар өнөөдрийн байгаагаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль явж байгаа.

Энэ дээр дунд нь 6-10 тэрбум төгрөгийн татвар ногдуулах орлоготой байвал 15 хувийн шатлалтай байна гээд ингээд шатлал нэмж байна л даа. Тэгээд энэ дээр сая аж ажлын хэсгээс би тайлбар авахад ажлын хэсгийн тайлбар дээр бол жишээлбэл яг энэ хоорондын шатлалд хэчнээн аж ахуйн нэгж байгаа юм бэ гээд аваад үзэхэд 338 компани гэж хариулж байна. Би бас энэ татварын байгууллагыг толгойлж ажиллаж байсан. Тэр үеийнхээ би яг судалгаануудыгаа 2023, 2024 оныхоо судалгааг аваад үзэхэд ийм хэмжээний их компани энэ энэ борлуулалт, татвар ногдуулах орлогын хэмжээнд байхгүй. Миний тооцоогоор. Энэ 100 орчим компанид л хүрэхтэй үгүйтэй л компани байх ёстой.

Гэтэл ингээд 338 компани гэж сая ажлын хэсэг дээр хариулж байна. Би энийг нь дахиж албан бичгээр явуулж энэ ажлын хэсэг дээр хариулт өгч байгаа энэ хариулт нь үнэн байна уу үгүй юу гэдгийг бас дахиж лавлах болно гэдгийг би хэлэх гээд байгаа юм. Тэгээд 100 хүрэхгүй компанийн шатлалтай холбоотойгоор 6-10 тэрбумын хооронд дахиад 15 хувийн татвар гэсэн ийм шатлал оруулж ирдэг нь би буруу гэж үзэж байгаа учраас энийг хасаад дараа нь найруулсан 2 ийм зүйл, заалтыг би бас оруулж ирж өгсөн. Ажлын хэсэгт бас оруулсан байгаа гэдгийг бас энд хэлье.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг.

Х.Ганхуяг: Тийм ажлын хэсэг дээр бол энэ асуудлыг нэлээн хэлэлцсэн. Тэгээд хэлэлцсэн шалтаг түрүүн би нэг тайлбарлалаа шүү дээ. Энэ 6-10-ын хооронд 15 шатлалыг Засгийн газрын өргөн барьсан энэ төсөл нь зөв юм байна. Худлаа, хуурамч тайлан хийхгүйгээр ингээд компаниуд нь томрох боломжийг нь өгье өө. Компаниудыг задалдаггүй, жижгэрүүлдэггүй байя. Компаниудыг бас гэнэт татварын шокт оруулдаггүй. Гэнэт 6 тэрбумтай байж байгаад 6 тэрбум 1 төгрөг болонгуут нөгөө юу гэдэг юм 7 тэрбум болонгуут нөгөө 1 тэрбум дээр дахиад 25 хувийн татвар гээд нөгөө компаниуд чинь 6 тэрбум руу дөхөөд эхлэхээрээ шинээр компани байгуулаад л ингээд л задлаад байдаг байхгүй юу. Тэгээд энэ дээр чинь сөрөг үр дагаврууд нь яах уу нөгөө компаниуд нь томордоггүй, захиргааны зардал нэмэгддэг. Дээрээс нь ярьж байгаа сая худалдан авахын асуудал ч гэдэг юм уу, санхүүжилтийн асуудал ч гэдэг юм уу олон сөрөг үр дагавар гардаг юм. Тэгээд хуурамч тайлан гарна гэх мэтчилэн асуудлууд байгаа юм.

Тийм учраас зүгээр Засгийн өргөн барьсан төсөл нь зөв юм байна гэж бодоод тэр шатлалыг үлдээх нь зөв юм байна гээд ажлын хэсэг шийдсэн шүү.

Н.Наранбаатар: Заяабал гишүүн зарчмын зөрүүтэй саналаа сая тайлбарласан. Одоо санал хураалтыг дахиж явуулна. Түрүүнийхийг хүчингүй болгосон.

1.Төслийн 2 дугаар зүйл, одоо Заяабал гишүүний өнөө төслийн 2 дугаар зүйлийг хасах гэдгээр явна шүү дээ. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Санал хураалт.

36.8 хувиар дэмжигдсэнгүй. Дараагийн санал хураалт.

Жаргалан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж өөрчилж, мөн хэсгийн “6-10 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах, тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 15 хувиар,” гэснийг, мөн хэсгийн “200 сая” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Жаргалан гишүүн тайлбарлаж хэлэх үү? Горимын санал Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Өнөөдөр энэ хурааж байгаа саналын томъёолол дотор чинь зөвхөн ажлын хэсгийн санал байгаад байдаг. Улсын Их Хурлын гишүүдийн Байнгын хороонд гаргасан зарчмын зөрүүтэй саналууд гишүүдэд тараагдаагүй. Юу хураагаад байгааг чинь ойлгохгүй суугаад байна шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Тэгээд энэ юмаа ойлгомжтой өгч байж энэ юмаа хийхгүй юм уу? Одоо саяын Заяабал гишүүний санал дээр асуудал үүсээд Заяабал гишүүн өөрөө саналаа хэлж байж санал хураагдаж байна.

Одоо Жаргалан гишүүний санал дээр уншаад байх юм. Бид нарт энэ юм чинь алга байна шүү дээ. Тэгээд яаж энэ санал хураалт явах юм бэ?

Н.Наранбаатар: Хурлаа цаашаа явуулъя. Нэгэнт байхгүй байгаа гишүүнийг хүлээгээд суугаад байх боломж байхгүй шүү дээ. Хэдүүлээ ажлаа явуулъя. Өгсөн саналыг нь би та бүхэнд уншаад танилцуулъя. Тэн дээр ингээд саналаа хураагаад л явъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “0-6” гэснийг “0-10” гээд өөрчилж, мөн хэсгийн “6-10 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах, тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 15 хувиар” гэснийг, мөн хэсгийн “200 сая” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Санал хураалт.

5.3 хувиар дэмжигдсэнгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс бэлтгэсэн саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн ““2.5 тэрбум” гэж”, гэсний дараа 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, “10-ны” гэснийг “5-ны” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, “20-ны” гэснийг “05-ны” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт

Аубакир гишүүн горимын санал гаргая. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Би сая дэмжиж санал өгсөн боловч энэ юу болсонгүй. Дахиад саналыг хүчингүй болгож өгнө үү. Дахин санал хураалт.

Н.Наранбаатар: Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ. Хүчингүй боллоо.

Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналаар санал хураалт явуулъя.

Заяабал гишүүнээс ирүүлсэн санал. Төслийн 4 дүгээр зүйлийн “22.5.4 дэх” гэсний өмнө “22.1 дэх хэсгийн 20.2.7” гэснийг гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал.

Заяабал гишүүн гаргасан саналаа тайлбарлах уу? Санал хураалт явуулъя. Санал хураалт.

42.1 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Дараагийн асуудал.

17.12 цаг.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг хэвээрээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Баярлалаа би энд асуулт биш үг хэлчихье гэж бодсон юм. Энэ зохицуулалтыг дэмжих боломжгүй байгаа юм. 5 үндэслэл байна. Ерөнхийдөө бол энэ НӨАТ гэдэг төрлийн татварын үндсэн суурь үзэл баримтлал, агуулга, зорилго буюу энэ бүртгэлийн тогтолцоог бүр ор үндсээр нь байхгүй болгох ийм ноцтой үр дагавартай учраас дэмжих боломжгүй байгаа юм. Ийм 5 үндэслэл байна.

1 дүгээрт, энэ өмнө нь бараг 2 жил гаруйн хугацаанд хийсэн хэлэлцүүлгийн үр дүнд маш олон аж ахуйн нэгжүүд энд ер нь санал ирүүлсэн бараг аж ахуйн нэгжүүд шат шатны аж үйлдвэрийн танхимуудаас бараг 90 гаран хувьтайгаар энэ НӨАТ төлдөггүй хэсэг нөхдүүдийг дундаас нь сугалчихсан энэ 40 гаран хуулиар НӨАТ төлөгч биш болгочихсон эдгээрийгээ болиоч ээ. Бүгдээрээ, бүх нийтээрээ НӨАТ төлөгч больё гэдэг энэ зөв. Энэ саналын бүр бодлогынхоо эсрэг явах гээд байна 1 дүгээрт.

2 дугаарт, одоо бид нэг энэ НӨАТ-ын тайлан гаргадаг 68 мянган аж ахуйн нэгжтэй юм. Үүний бараг 23 гэдэг чинь бараг 34 хувь нь НӨАТ-ын тайлан гаргахгүй байх үүд нээгдэх нь. Үүд нээгдэнэ. Энэ нь тэгээд 1 ижил төрлийн бизнес эрхэлдэг боловч 2 зэрэгцээ дэлгүүр нь нэг нь НӨАТ-тай, нэг нь НӨАТ-гүй гэдэг ийм шударга бус татварын тогтолцоо бий болно гэж.

3 дугаарт, энэ НӨАТ-ын систем НӨАТ гэдэг татварын төрөл маань бүр 2005 онд анх эхэлсэн юм. 2016 онд И-баримтын систем рүүгээ ахисан түвшин рүүгээ орсон ийм өөрчлөлт гарсан. Ийм 2 үе шаттай явж ирсэн юм. Одоо ингээд үндсэндээ бараг 3 дахь үе шат руугаа явж ирэх гэж байна.

Анх эхэлж байхдаа бол мэдээж 0-ээс эхэлсэн. 16 онд И-баримттай НӨАТ руу шилжихэд 45 хувьд хүрчихсэн байсан. Тэрнээс хойш 10 жилийн дотор одоо 74 хувьд хүрчихсэн явж байгаа энэ бүртгэлийн систем маань. Энэ маань өөрөө огцом буурах ийм үүд нээгдэх нь. Магадгүй 23 мянга маань бүгд биш юм гэхэд ийм үүд нээгдэнэ. Ийм тэнцвэргүй шударга бус байдал руугаа бид буцаад жижиг аж ахуйн нэгжүүдийгээ далд эдийн засаг руу гэж бид өөрсдөө аягүй эвгүй нэрлэдэг. Гэтэл тэр чинь далддаа биш бид өөрсдөө хуулийнх нь ийм боломжийг нээж өгчхөөд байгаа учраас энэ рүүгээ түлхэж оруулах ийм эрсдэл, сөрөг эрсдэл байна. Бодлогын том ухралт болно гэж.

4-д нь НӨАТ суутган төлөгч биш ЖДҮ нь борлуулалтаа хийгээд эхлэх тул, энэ НӨАТ-гүй борлуулалтаа хийгээд эхлэх тул нөгөө том аж ахуйн нэгжүүдтэйгээ харьцахад ийм ялгаварлал.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмж минут өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр нөгөө том аж ахуйн нэгжүүд маань эд нарыгаа эрэмбэлээд эхэлнэ. НӨАТ-тай НӨАТ-гүй. Гөвөөд ирэхлээр нь мэдээж НӨАТ-тайгаас нь л авна. Дэлгүүр ч байсан гэсэн. Тэгэхээр нөгөө том, жижгийн ялгаанууд нь ингээд эрс өндөр болоод явчихна.

5 дугаарт, энэ босгыг та 50-аас 400 болгоно гэдэг маань ямар нэг тийм татварын хөнгөлөлт чөлөөлөлт огт биш. Огт биш. Энэ нөгөө тайлагналтынхаа босгыг л 50-ийг 400 болгож байгаа. Өөрөөр хэлбэл, төсвийн орлогод нөлөөлөх гээд талаас нь, нөлөөлөх гээд байгаа эрсдэлийн талаас нь хэлж байгаа зүйл огт биш шүү энэ бол. Орлогод бол шууд тэр хувь хүний орлогын албан татвар шиг бол маргаашаас нь шууд нөлөөлөхгүй юм.

Харин хамгийн гол НӨАТ-аар дамжиж энэ татварын өөрөө том тогтолцооныхоо бүртгэлийн системээ унагааж хаях маш том эрсдэл рүү явж орох учраас энийг ийм ийм үндэслэлээр дэмжих боломжгүй байна. Тийм учраас одоо.../минут дуусав./

Н.Наранбаатар: 2 дугаар. Саяынх 2 дугаар зүйлтэй холбоотой шүү.

Одоо 1 дэх саналын томъёолол. Төслийн 1 дүгээр зүйлийн 16-гийн штрих 5 дахь хэсгийн тайлбарын “Барааг” гэснийг “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан барааг” гэж өөрчилж, мөн зүйлийн 16-гийн штрих 11 дэх хэсгийн “бол тухайн татварын” гэсний өмнө “шийдвэр гарсан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад бэлтгээрэй гишүүд. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Заяабал гишүүн.

П.Сайнзориг: Би асуучихъя. Би энэ ажлын хэсгийн саналыг дэмжиж байна. Гол асуудал энэ НӨАТ-ын босгыг 400 сая болголоо гээд өнөө маргаашдаа их гоё сонсогдож магадгүй. Тэгээд энэ жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагуудтай чинь ер нь яг голлох худалдан авалт хийдэг томоохон аж ахуйн нэгж байгууллагууд чинь аяндаа харьцахаа болино л гэсэн үг. Эсвэл тэд нарын өмнөөс дахиад 10 хувийн татвар төлөөд л ийм бүртгэл, мэдээллүүд ингээд л явна.

Энэ нь өөрөө эргээд бас жижгүүдийг нэг их дэмжих гээд байгаа билүү гэхээсээ илүүтэй дунд хугацаандаа ерөөсөө бизнес бойжиж ирэх бололцоог нь бүрдүүлэхгүй болчих гээд байгаа байхгүй юу. Түүх үүсэхгүй ерөөсөө томхон аж ахуйн нэгж байгууллагатай худалдаа ч байдаг юм уу, эсвэл сав контрактороор эвтэйхэн ажилласан түүх үүсэхгүй. Тэгэхээр ер нь зүгээр ингээд жигдхэн төлдөг энэ нөгөө шударга ёсны зарчим руугаа ороод харин буцаалт нь ямархуу хэмжээгээр онцлогууд байх вэ гэдгээ л бодмоор байна. Тэрнээс биш ингээд босгоод энэ ингээд эксепшн хийчихнэ. Тэгээд энэ жижиг аж ахуйн нэгж байгууллагууд ер нь бойжихгүй.

2 дугаарт, сая энэ Аубакир гишүүн сууж л байна л даа их төлбөл бас их л тэтгэвэр авна гэдэг шиг яг энэ бүх зүйлүүд дээр ийм шударга баймаар байна. Бүгд төлбөл төлөөд. Тэгээд энэ зарчмаа ер нь хадгалж бас энэ татварын юунуудыг авахгүй бол үе үеийн улс төрийн өнцгөөс таалагдах гэдэг юм уу ийм хэмжээнд л татвар бараг төлөгдөхгүй байхгүй болчих гээд байгаа шүү гээд ингээд нийтдээ жоохон мэдээлэл дутуу хүмүүс бол энэний үр дагаврыг тооцохгүйгээр их л гоё санаа байна гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгээд алсдаа бол энэ манай бизнесийн систем энэ бүх зүйлүүд дээр ер нь асуудлууд үүснэ. Тийм учраас ажлын хэсгийн саналыг дэмжээд явах нь зүйтэй. Хуучнаар нь тавт. Болдог бол бүгд жигд төлмөөр байна. Бүүр болдог бол бүгд жигд төлнө.

Ганхуяг гишүүн чинь өөрөө ажлын хэсгийг ахалж байхдаа бүүр энэ төрийн байгууллагууд хүртэл НӨАТ төлөх, төлье гэж байсан шүү дээ. Ингэж жигд байхгүй бол зарим энэ төрийн байгууллагууд яах вэ бизнесийн зарчмаар явах шаардлагыг нь бид нар тавих ёстой байхгүй юу. Тэгээд явж чадахгүй бол больдог байх хэрэгтэй. Тэгэхгүй ингээд баахан янз янзын дэмжлэг, татаас, давуу талууд олж авчхаад тэгээд ингээд бизнесийн орчиндоо муухай харагдаад, хувийн хэвшил нь барьцдаг, талцдаг. Энэ чинь л муухай харагдуулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр

энэ зарчим руугаа уг нь явмаар байна. Энийгээ бас зөв цаашаа тайлбарлаасай, иргэд олон нийтэд зөв ойлгуулаасай.

Харин буцаалтын тэр хувь, хэмжээ энэ тэр дээр маш сайн тооцоотой ер нь дараагийн хувилбаруудыг бас Засгийн газар маань оруулж ирээсэй гэж бодож байна.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн асуулт асууна. Заяабал гишүүн, түрүүн би Заяабал гишүүн гэсэн ийшээ шууд өгчихнө лээ. Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Баярлалаа. Би энэ 2 дугаар зүйлтэй холбоотой хэд хэдэн асуулт асууя. Яг үнэндээ, товчхондоо бол би 50 саяыг 400 сая болгоё гэж Засгийн газрын оруулж ирсэн энэ саналыг дэмжиж байгаа. Гишүүдийг бас би дэмжихийг уриалъя. Ингээд хэд хэдэн асуулт асууж бас гишүүдэд бодит мэдээллийг бас өгөх нь зөв байх гэж ингэж бодож байна. Ажлын хэсэг харин энэ дээр нэлээн судалгаа, тооцоотой хариулж өгөхийг хүсье.

50 сая төгрөгийн борлуулалтын орлогын босго 2015 онд орж ирсэн. Өмнө нь 2007 оны 4 арвын зарчим гэж байх тэр үед бол борлуулалтын орлого, НӨАТ-ын албан татварын борлуулалтын орлого 10 сая төгрөг байсан. Ингээд 8 жилийн дараа бараг 10 жилийн дараа 2015 онд борлуулалтын энэ хэмжээг 50 сая болгож өсгөж оруулж ирсэн. Энэ үед бол би яг энэ судалгаануудыг нь уншиж байсан л даа.

2015 онд борлуулалтын орлогыг 4 дахин нэмээд ороод ирэхэд 10 байсныг 5 болгоод 4, 5 дахин нэмээд ороод ирэхэд НӨАТ төлөгчийн тоо нь буурах байх гэсэн ийм тооцоо судалгаа анх хуулийн төсөл оруулж ирж, үзэл баримтлал дээр нь бүгд дээр нь яг яг ийм тооцоо оруулж ирж байсан. НӨАТ төлөгч хасагдана, 10 мянгаар хасагдана, энэнтэй холбоотой улсын төсөв 100 тэрбум төгрөгийн орлого багасна гэсэн яг ийм томъёоллоор оруулж ирж байсан.

Яг хууль хэрэгжээд жилийн дараа энэ нь эсрэгээрээ НӨАТ төлөгчийн тоо нэмэгдсэн байдаг 2016 онд. Яг энэнтэй холбоотой би асуух гээд байгаа юм. 2025 онд яг хэд байгаа юм та нарын тооцоогоор бууна гэж үзэж байгаа юм уу?

2 дугаарт нь, цаг байгаа учраас 2 дугаарт нь энэ 50 саяын борлуулалтын орлогоос 400 сая болгоод өсгөж байна тийм үү 4 дахин дахиад өсгөж байна, 8 дахин. Энэ дээр холбоотойгоор яг энэ 50 сая байсныг 400 сая болгосонтой холбоотой аж ахуйн нэгжүүд хэд байгаа юм? Тэр аж ахуйн нэгжүүд том гээд байгаа юм. Томууд нөгөө жижгүүдийг тоохгүй хоорондоо харьцахаа байчихна гээд байна шүү дээ. Тэр хоорондын харьцаа энд борлуулалтын орлого нь хэд байгаа юм? Тэр нь яг томуудын яг гаргаж байгаа аж ахуйн нэгжтэй харьцаж байгаа нийт борлуулалтын, хоорондоо харьцаж байгаа борлуулалт, гүйлгээний яг хэдэн төгрөг байгаа юм. Тэр нь томуудын харьцаж байгаа нийт гаргаж байгаа энэ аж ахуйн нэгжтэй харьцаж байгаа энэ борлуулалтынхаа орлогын хэдэн хувийг эзэлж байгаа юм бэ гэдэг дээр 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ бөөгнөрөл байна шүү дээ. 50 сая төгрөг байхаар энэ чинь аж ахуйн нэгжүүд чинь ихэнх 200-аад аж ахуйн нэгжүүд чинь 50 саяас бага болох гээд бөөгнөрөл үүсээд байна шүү дээ. Энэ бөөгнөрөл чинь жишээлбэл тэгвэл 48-50 саяын хооронд борлуулалтын орлоготой хэчнээн аж ахуйн нэгжүүд яг энэ татварын систем дээр бүртгэлтэй байна. 45 саяас 48 саяын хооронд бүртгэлтэй

хэчнээн аж ахуйн нэгжүүд байна. Энэ дээр та нар минь аж ахуйн бид нар бөөгнөрөл гэж ярьдаг. Энэ дээр та нар тодорхой хариулт өгөөч.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Бид нар бол сая харамсалтай нь НӨАТ-ын буцаалтыг ихэсгэх 100 хувиар бол буцаалт өгөх, 50 хувиар буцаалт өгөх хуулийг бол ингээд хүчингүй болгочихсон. Гэхдээ бас тэрийг бол эргэж судалж байгаад оруулж ирэх нь бол зөв гэж боддог би бол хувь хүнийхээ хувьд. 2 жилийн хугацаанд энэ татварын хуулийг судалсан, сүүлийн 28 жил татвар төлөгч байсан хүний хувиар хэлэхэд бол татварын бүхий л асуудлуудыг бол тал талаас нь үзэхэд бол бид нар бүгдээрээ л НӨАТ төлөгч байх ёстой юм байна лээ. Гадаадын олон орны судалгааг үзлээ, олон орны туршлагыг үзлээ. Ер нь бол төр засаг нь хүртэл НӨАТ төлөгч байхыг хуульчилсан байдаг.

Яагаад тэгж байна гэхээр энэ сургууль, цэцэрлэг эд нар нь эргээгээд НӨАТ-гүй бараа эд нар аваад эхэлдэг. Тэгээд тэр нь эргээгээд бүртгэлгүй саарал эдийн засгийг том болгодог гээд асуудлууд байна. Энэ бол НӨАТ гэдэг маань бүртгэлийн татвар гэдгээ бас бид нар хаа хаанаа ер нь бас ойлгож байгаа болов уу гэж бодож байна. Тэгээд ажлын манай Чимидсүрэн нэмээд хариулна биз дээ.

2 дугаар асуудал бол ялт ч үгүй бид нар Хувь хүний орлогын албан татварын хуультай холбоотойгоор нэлээн хэмжээний татварын хөнгөлөлт үзүүлэх гэж байна яг нөгөө хувь хүмүүстээ. Хувь хүний цалингаас адилтгах орлого дээр. Тийм болохоор бид нар энэ НӨАТ дээр дахиад нэмж ингээд хөнгөлөлт үзүүлэх энэ асуудал бол төсөв бол дийлэхгүй. Яг ний нуугүй л хэлэхэд бид нар бол энэ татварын хуулийн дараа намар Засгийн газар төсвөө базаж орж ирэхэд бол нэлээн хүндрэлтэй байх болно. Ер нь бол нэлээн хэмжээний хэмнэлтийн бодлого барьж явах шаардлагатай болно. Тэгж байж ирэх жилийн төсвийг барих болов уу гэж бодож байна.

Тэгэхгүй бол яг одоогийн байдлаар ерөөсөө ингээд бүх хуулиуд нь нэг бол халамж олгоно гэдэг, нэг бол татвар бууруулна гэдэг ийм л хуулиуд бид нар хэлэлцдэг болчихлоо. Тэгснээрээ бол 1 дүгээрт төсөв бол нэмэгдэхгүй. 400 болгосноор би бол татвар, НӨАТ төлөгчийн тоо нэмэгдэхгүй гэж бодож байна. 400 сая болгосноор төсөв нэмэгдэж орж ирнэ гэж би бол ерөөсөө бодохгүй байна.

Тийм учраас энэ удаадаа яах вэ магадгүй энэ удаадаа энэ хувь хүнийхээ юун дээрээ илүүтэй ингээд бид нар бүх боломжоо ийшээ шавхаад байна шүү дээ. Тэгэхээр бол магадгүй энэ удаадаа ингэчихье. Магадгүй энэ 400 саяын босгыг нэмэгдүүлэхдээ НӨАТ-ын буцаалттайгаа хамт оруулж ирвэл ирвэл ирвэл магадгүй бас нэг зөв хувилбар байж болох юм гэж бодно.

Тэгэхгүй бол НӨАТ-ын буцаалт нь больж хаячхаад энд 400 саяыг нь ингэчихээр эргээгээд нөгөө саарал эдийн засаг нь л томрох ийм л арга хэмжээ болчих болов уу гэж санаа зовнил байсан юм, болсон юм яг ажлын хэсэг дээр бол. Баярлалаа.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Индрийн микрофон.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар, Цогтнаран. Заяабал гишүүний асуултад хариулъя. Татвар төлөгчдөөс татварын албанд ирүүлсэн 2025 оны

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн нэгтгэл мэдээнээс асуусан асуултад хариульъя.

НӨАТ-ын босго 50 саяас 400 сая төгрөг бол болж нэмэгдэж байгаатай холбоотойгоор энэ 50-аас 400 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой 23.4 мянган аж ахуйн нэгж НӨАТ суутган төлөгч байгаа.

2025 онд батлагдсан энэ 26 оны 01 сарын 01-нээс хэрэгжээд өнөөдрийг хүртэл мөрдөгдөөд явж байгаа энэ нэмэгдсэн өртгийн албан татварын босго яригдаж байх үед бол 10 сая төгрөгийн босгыг 50 сая төгрөг болгож нэмэгдүүлэхэд тухайн хууль батлагдах үед бол НӨАТ суутган төлөгч 9100.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмж хариульъя.

Б.Цогтнاران: НӨАТ суутган төлөгчийн тоо 9100 буюу тухайн үед байсан НӨАТ суутган төлөгчийн 28.5 хувиар буурч болзошгүй. НӨАТ-ын орлого 7 тэрбум төгрөгөөр буурч магадгүй гэдэг ийм зүйл яригдаж байсан.

Харин яг бодит 2016 онд бол эсрэгээрээ НӨАТ суутган төлөгчийн тоо бол 1250-аар нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, НӨАТ суутган төлөгчийн тоо 3.6 хувиар нэмэгдэж, НӨАТ-ын орлого бол 15 хувиар өссөн гэдэг ийм дүн, мэдээ, статистик тоо мэдээ байна.

400 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдээс томоохон гэж нэрлэгдээд байгаа аж ахуйн нэгжүүд нь нийт худалдан авалтынхаа хэдэн хувийг авдаг вэ гэдэг ийм асуултыг асуулаа.

400 саяас дээш төгрөгийн борлуулалттай аж ахуйн нэгжүүд бол НӨАТ-ын тайлан дээр тайлагнасан тайлангийн мэдээгээр бол нийт 80.5 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийсэн гээд. Энэ худалдан авалтуудаас 2.2 их наяд төгрөгийг нь.../минут дуусав./

Н.Наранбаатар: Гүйцээж хариульъя Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Засгийн газар энэ удаагийн татварын багц хуулийг өргөн барихдаа нийт бол 2.2 их наядын төсвийн орлого болон татаасны юугаар өргөн барьсан байгаа. Зөвхөн хувь хүний орлогын албан татвар бол 840 тэрбумын төсвийн орлого буурна. Нөгөө талдаа тэр хэмжээгээр татаас нэмэгдэнэ.

Тийм учраас одоо энэ Баярмаа гишүүдийн хуулиудтай ингээд нэгтгэснээр тэр 840 тэрбум чинь бараг ойролцоогоор 1.8 их наяд төгрөг болж байгаа юм. Энэ талдаа 1.8 их наяд төгрөгийн орлого буурна. Энэ талдаа 1.8 их наядын татаас нэмэгдэнэ. Нийт 3.6 их наяд. Энэ НӨАТ-ын хууль 400 сая болгосноор бид нар дахиад 180 тэрбум төгрөгийн орлого алдана. Үгүй тэгээд ийм байхад бид нар яаж энийг чинь явуулах юм бэ? Магадгүй тэр НӨАТ-ынхаа хуулиа дараад нь тэр буцаалттай нь хамт оруулж ир ээ. Энэ удаа бол энэ төсөв чинь дийлэхгүй нь. Би бол ийм юм явуулж чадахгүй ээ. Үгүй ээ гэж байвал тэгээд намайг ажлын хэсгийн ахлагчаас нь тэгээд буулгаад л өөрснөө ахлаад л явуул л даа.

Н.Наранбаатар: Сангийн яам нэмээд хариулчих. Түрүүн Сангийн яамнаас асуусан.

Ч.Чимидсүрэн: Сангийн яам Чимидсүрэн. Одоо НӨАТ суутган төлөгчөөр 69 мянган аж ахуйн нэгж байгаа. Хэрэв ингээд НӨАТ-ын босго 400 сая болох юм бол 400 сая хүрээгүй буюу 23 мянга бол суутган төлөгчөөс бол хасагдах боломжтой гэсэн үг. Энд төсвийн нөлөөлөл нь бол 160.8 тэрбум буюу 161 тэрбум орчим байгаа юм.

Тэгээд интервалаар нь аваад үзэх юм бол 69392 аж ахуйн нэгж бол суутган төлөгчөөр бүртгэлтэй байна. Үүнээс 50 сая хүртэл борлуулалттай нь 21269, 50-300 сая хүртэлх нь бол 20030, 300-400 саяын борлуулалттай нь бол 3398. Ингээд 400-аас 1.5 тэрбумын ийм борлуулалттай.../минут дуусав./

Н.Наранбаатар: Гүйцээгээд хариулъя. Заяабал гишүүн тодруулъя. Индрийн микрофон гүйцээгээд хариулчихъя.

Ч.Чимидсүрэн: 400 саяас 1.5 тэрбумын борлуулалттай нь 14355, 1.5-2.5 тэрбумын борлуулалттай нь 3374, 2.5-аас дээш нь бол 6967 гэсэн ийм мэдээлэл байна. Нөгөө 69 мянган аж ахуйн нэгжийн татвар ангилаад аваад үзэх юм бол.

Тэгэхээр НӨАТ дээр энийг бид нар бас сайн ярьж бас шийдэх нь бас зүйтэй байж магадгүй. Яагаад гэвэл энэ НӨАТ-ын татварын тухай хууль НӨАТ-ын систем дээр бол нэлээн асуудлууд бол бий. Тэгэхээр нөгөө өмнөх төсөл дээр нэлээн ажилласан хүмүүс маань одоогийн байгаа 2 дээр ингээд бас нэлээн ойлголтын зөрүү нь бол бас нэлээдгүй бас гараад байгаа байх.

Тэгэхээр өмнөх төсөл дээр бол ер нь бүх нийтээрээ татвар төлөгч байя, НӨАТ төлөгч байя гэдэг энэ концепцоор бол боловсрогдоод явсан. Дамаа бусад улс орны Шинэ Зеландын сайн жишээ эд нар гэдгийг аваад бол нэлээн боловсруулалт хийгдсэн зүйлүүд байгаа. Тэгээд тэр дээр нэлээн хэдэн тохируулга хийж байж энэ систем цогцоороо бол шийдэгдэх ёстой.

Н.Наранбаатар: Заяабал гишүүн.

Б.Заяабал: Баярлалаа. Сая Чимэдцэрэн даргын хариултаас үзэхэд ер нь Засгийн газар оруулаад ирчихсэн юмыг өмнөх хуулийн төслүүдийн өмнөх ажлын хэсэг дээр ажиллаж байсан юмнуудтайгаа холиод бараг буруу ойлгоод байна гэсэн ийм агуулгатай юм хэлчихлээ шүү дээ хамгийн сүүлд. Та нар энэнийхээ ойлголтыг нь ялгааг нь гаргаж ойлгож байгаа юм уу? Өмнө чинь 400 сая хүртэлх орлоготой байвал Шинэ Зеланд явж ирсэн туршлага гээд аваачаад 1 хувийн татвар бараг нийт орж ирсэн, худалдан авсан орлогын 90 хувьд нь хасалт хийнэ энэ тэр гээд ерөөсөө өөрөө үндсэн НӨАТ-ынхаа бүртгэлийнхээ системийг үгүйсгэсэн ийм хуулийн заалт явж байсан. Харин азаар тэр нь ер нь өөрчлөгдөж харин зөв болж орж ирж байгаа юм. Энийг бол бид нар бол дэмжих ёстой гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд саяын асуулт дээр, хариулт дээр ярьж байна шүү дээ 400 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн борлуулалт нь нийтдээ 80.5 их наяд төгрөг байдаг юм байна. 400 саяас бага борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд тэр 80.5 их наядынхаа 2.2 их наядыг нь жижиг 400 саяыг нь босгоос чөлөөлөгдөөд байгаа аж ахуйн нэгжүүд дээр ноогддог юм байна гээд аваад үзэхээр зэрэг 80-ын чинь 2.2 гэхээр чинь асар бага хувь байна шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт, өмнөх НӨАТ-ын хуулиар 10 сая байсныг 50 сая болгочихсон байхад нэгэнт том аж ахуйн нэгжүүдтэйгээ НӨАТ-ын харилцаанд орчихсон орчихсон аж ахуйн нэгжүүд буцаад НӨАТ-аасаа гардаггүй байхгүй юу даа. НӨАТ суутган төлөгчийнхөө үүргээсээ гардаггүй. Сая та нарын яриад байгаа энэ том аж ахуйн нэгжүүд жижгүүдтэйгээ харьцахаа байчихна гээд байдаг чинь энэ дээр байхгүй болчихно. Том аж ахуйн нэгжүүдтэйгээ харьцаагаа хадгалахын тулд нөгөөдүүл сайн дураараа нөөц суутган төлөгчийнхөө үүргээ гүйцэтгээд харьцаандаа ороод яваад байдаг. Өмнөх 15 оны хууль чинь яг тийм кэйс нь байгаад байгаа байхгүй юу даа.

Тэгээд өнөөдрийн энэ юуг хараад байхад зэрэг том аж ахуйн нэгжүүдийн дуу хоолой аягүй өндөр, том аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг аягүй их хамгаалдаг, voice гаргаж байгаа чадвартай аж ахуйн нэгжүүд нь аягүй том аж ахуйн нэгжүүд байдаг. Нөгөө нэг дугуй засвар, нөгөө нэг цайны газар ажиллуулж байгаа хүмүүс нь дуу хоолойгоо гаргаж чаддаггүй. Энэнээс.../минут дуусав./

Н.Наранбаатар: Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Би ийм хэдэн санал хэлэх гэсэн юм. НӨАТ-ын босгыг өндөрсгөнө гэдэг дээр бол түрүүний би Жавхлан сайдтай бас байр суурь нэг байгаад байгаа юм. Яагаад гэвэл 2016 онд энэ хэрэгжиж эхэлсэн бас амжилттай хэрэгжсэн төсвийн аягүй том бүтэц болсон, бүтэц бүрэлдэхүүн болсон. Бид нар бол үүнийг нэг бүтэн гинжин цикл гэж хардаг. Энэ бүтэн гинжин цикл дотор хаа нэгэн газар тасралт үүсэх ёсгүй.

Иргэдийн бухимдаад байгаа зүйл нь болохоороо нэг хэсэг нь НӨАТ төлөгч, нөгөө хэсэг нь НӨАТ төлөгч биш, би татвар төлөгч гэхэд нөгөөдөх нь татвар төлөгч биш байна гэдэгт л бухимдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр их ч бай бага ч бай өөрийнхөө олсон орлогоос бид нар энд татвар дээр бид нар ачаалал үүрэх ёстой гэдэг татварын шударга байдал, хамрагдалт гэдэг нь би сая энэ өргөн барьсан бичиг баримтыг харахаар хамрагдалтыг нэмэгдүүлэх гэдэг бол номер нэг асуудлын нэг юм байна гэж бодсон.

Одоо үүсээд байгаа нөхцөл байдал би бол юу гэж харж байна вэ гэхээр яах вэ Заяабалтай санал нэгтэй байгаа нь одоо том татвар төлөгчтэй харилцаанд орсон компаниуд бол бараг үгүй байх. Гэхдээ энэ удаагийн НӨАТ-ын буцаан олголттой холбоотой харилцаа нь аж ахуйн нэгжүүдээ дэмжих гээд байгаа юм уу, иргэдээ дэмжих гээд байгаа юм уу? Одоо нөхцөл байдлыг ийм юм үүсчхээд байгаа байхгүй юу. Өнөөдөр манай бид хэд манай хэд хэдэн эмэгтэй гишүүд очиж оролцсон Эмэгтэй захирлуудын ингээд клубийн юун дээр судалгаа дээр аваад үзэхэд би өнөөдөр үйлдвэрлэгч уже биш болчихсон байхад би НӨАТ төлөх болчихоод байгаа байхгүй юу.

Би яагаад гэвэл нэг жижигхэн үйлдвэр барих гээд 3 жил барилгын ажил эхлүүлсэн надад ханган нийлүүлэлт хийж байгаа бүх компаниуд НӨАТ төлөгч биш болчихсон байвал би НӨАТ төлөгч биш ч гэсэндээ би тэд нарын өмнөөс НӨАТ-ыг нь төлнө. Ингээд би ямар ч орлого олохгүй би 3 жил барилгын ажлын явцад орлого олохгүй. Би дараагийн 3 жилд магадгүй миний үйлдвэрлэл жигдэртэл би орлого олохгүй. Тэгэхдээ би НӨАТ төлөгч биш ч гэсэндээ би тэд нарын НӨАТ-ыг төлнө.

НӨАТ-ын энэ харилцаан дээр бизнесүүдийн санаа зовоод байгаа зүйл нь болохоороо намайг миний бизнесийг тогтворжтол энэ НӨАТ бол маш том дарамт байгаад байна. Энэ үйлдвэрлэлүүдийг хэрвээ дэмжинэ гэвэл ялангуяа энэ нэг циклүүдээр нь авч үзэх цаг бид нар болчихсон юм биш үү. Өмнөх Татварын багц хуулийн үед би дэд сайд байсан би 7 хоног би салбар салбарынхантай хэлэлцүүлэг хийж байсан. Би тэр үед сайн санаж байна. Тэр үед зарим нэг юмыг өнөөдрийн хэмжээнд авч хэлэлцэхэд аягүй хүнд байсан юм.

Яагаад гэвэл цахим энэ мэдээлэл өнөөдрийнх шиг байгаагүй. Одоо бол би Сангийн яамыг юу гэж харж байна вэ гэхээр Татварын ерөнхий газрыг та нар аягүй залхуу байна. Та нар хувь хүний орлогын албан татвар гэж байхад хэдүүлээ хамтдаа энийг хийж байсан шүү дээ. Манай татварын хэд хэдэн дарга нар надтай хамт сууж байна. Тэгэхэд бид нар тэр үед хувь хүн, хувь хүний орлогын албан татварын тайлан өгнө гэхэд одоогийнх шиг мэдээлэл байгаагүй. Цахим мэдээлэл байгаагүй. Одоо бол та нарт хувь хүний мэдээллүүдийг ч гэсэн тэр НӨАТ-ын мэдээллүүдийг ч гэсэн аж ахуй нэгжүүдийн мэдээллүүдийг маш нарийнаар авч хэдүүлээ ялгах бүрэн боломжууд бий болсон. Тэгэхэд.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмж минут өгье.

Х.Булгантуяа: Тэгэхэд одоо хүртэл яг л нэг ийм номиналны хэдэн дүн тавиад л. Одоо тэгээд яах юм? 100 мянган доллар гэдэг ханшийн зөрүү үүсэхээр хэдүүлээ яах вэ? Ахиад хуульд өөрчлөлт оруулах уу? Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхөөр яах вэ? Ахиад хуульд өөрчлөлт оруулах уу? Ингээд ийм нэг ийм залхуу байдлаар шийдээд байгаа чинь ерөөсөө болохгүй байгаа байхгүй юу. Эсрэгээрээ би бол энэ удаагийн өөрчлөлтөөс юу хүсэж байсан бэ гэхээр би 3 хүүхэдтэй. Тэгэхээр би 3 депеденттэй би авч явах миний ар гэрийн амьдралын ачаа илүү өндөр. Тэгвэл надад татварын хөнгөлөлт үзүүлэх ёстой. Би өнөөдөр дөнгөж үйлдвэрээ босгож байгаа.

Тэгвэл би НӨАТ төлөгч би одоохондоо биш болоогүй учраас би хүмүүсээс НӨАТ-аас худалдан авалт хийсэн ч гэсэндээ надад тэрүүнийг тэгвэл буцаагаад би НӨАТ-тай худалдан авагчаас би худалдан авалт хийчихлээ гэхэд тэрүүнийг надад буцаагаад олгодог байх ёстой. Би өнөөдөр 100 мянган долларын үйлдвэр барихын төлөө 40 орчим хувийн би татвар төлөөд би 1 ч төгрөгийн орлого олоогүй мөртөө 140 орчим мянган долларын зарлага гарах болчихоод байгаа байхгүй юу Монголын хуулиар. Би үүн дээр нэлээдгүй өөрчлөлт хийх юм байна гэдэг ийм хүлээлт байсан. 10 хэдэн жилийн өмнө хэдүүлээ хамтдаа өмнөх Татварын хуулийг хийж байхад бид нарт ийм цахим мэдээлэл байхгүй байсан болохоор хийж чадахгүй байсан. Одоо цахимжилт их сайн явсны үр дүнд та нарт ийм боломж бий болсон.

Тэгээд л ахиад л нэг номинал дүн тавиад л, үүгээр тайраад, энэнээс доошоо хөнгөлөлт, энэнээс дээшээ тэд, 5 жилийн өмнөхтэй, 10 жилийн өмнөхтэй харьцуулахад ийм байгаа учраас дүнгээ өсгөнө гэдэг биш арай ухаалгаар хийх, шийдэх цаг болоогүй юм уу? Одоо хэдүүлээ миний бодлоор 5 жилийн дараа энэ бүгдээ ахиад өөрчлөх байх Байнгын хорооны даргаа, ажлын хэсгийн даргаа. Яагаад гэвэл энэ бүх тоонууд бол ахиад өөрчлөгдөнө. Хэдүүлээ энэ ханш, энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг барихгүй нь ойлгомжтой. Тэгэхээр ахиад л өөрчлөгдөөд л ахиад л ард түмний мэдээж тэр үед захиалга, хүсэл эрмэлзэл бий болно. Тэр үед дахиад л хуульд өөрчлөлт орно. Уг нь бол.../минут дуусав./

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Ойлгомжтой хар Заяабал гишүүн ээ би үгээ хэлчихье. Ингэж хэлж байна шүү дээ НӨАТ бол татвар биш, НӨАТ бол бүртгэл юм гээд хэлчихсэн шүү дээ. НӨАТ татвар биш, бүртгэл юм бол тэр 50 хувийн буцаалт буюу 10 хувийнхаа тэр юуг шийд л дээ. Тэрийгээ шийдээгүй байж одоо зөвхөн төсвийн орлого талаа хараад энэ босгохгүй болгоё гэдэг чинь шударга биш болчихоод байгаа байхгүй юу. Бид нар угаасаа нэг юмыг ярихдаа нэг өнцгөөс нь яриад бүх л том зургаар нь харахгүй байна. Энэ татварын багц хууль дотор чинь хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, тэгээд онцгой бүгд орж байгаа нэмээд энэ НӨАТ.

Тэгээд НӨАТ-ыг нэг болохоор хэрэг болохоороо татвар биш гээд, нөгөө болохоороо төсвийн орлого бүрдүүлэгч гээд татвар болгоод, тэгснээ нөгөө талдаа бүгдийг нь бүртгэмээр байна гээд. Тэгвэл бүгдийг нь бүртгэхээр байгаа бол тоон дээрээ битгий анхаараач. Харин НӨАТ-ынхаа, НӨАТ төлөх гэж байгаа тоон дээр анхаараач. Төлж байгаа мөнгөн дээрээ биш тийм биз дээ шударга байя л даа. Тэр манай Засгийнхан битгий бие биетэйгээ шивнээд бай. Яг шударга сонсьё.

Одоо Заяабал гишүүний хэлж байгаатай би санал нэг байгаа юм. 16 онд 2 хувийн буцаалт ярьж байхад дахиад төсвийн орлого дутна гэж байсан бол 558 тэрбум чинь 18 онд 900 тэрбум болсон НӨАТ-аас орж байгаа орлого чинь. 21 онд 3.7 их наяд төгрөг болсон. Одоо манай төсвийн орлогын 23 хувь дунджаар бүрдүүлэгч болчихсон шүү дээ. Энийг яагаад одоо болохоороо татвар биш гээд байгаа юм. Тэгвэл тэгээд амархан шүү дээ. Татвар биш юм бол төсвийн орлогын гол бүрдүүлэгч чинь бол шууд буулга л даа. Шууд тэгвэл 5 биш бүүр 8 хувийг буцааж өг л дөө. Бүртгэ, бүртгэж аваад 100 хувь буцаахгүй юм гэхэд ядаж 20 хувийг авч үлдээд буцаа л даа гэж ярина шүү дээ. Логиктой баймаар байгаа байхгүй юу. Хүмүүсийг ингээд гөлөг төөрүүлж байгаа юм шиг гэдэг чинь яг энэ дээр гараад байна.

Тэгээд тэр Булгантуяа гишүүний хэлээд байгаа хүн амын орлогын албан татварыг нь ингэвэл, тэгвэл аль нь зөрөөд хаанаасаа нөгөө татвар төлөгчийнхөө тоог аж ахуйн нэгж, хувь хүн байлгаж байгаад нэмж байгаад олж ирэхийн тэр балансаа гарга л даа. Ерөөсөө томъёо симуляцад загвар гарахгүй, тооцоолол хийхгүй нэг нэгээр нь аваад нэг нэгээр нь арифметик тоо нэмж хасаад байхаар чинь энэ чинь гарч ирэхгүй байгаад байгаа байхгүй юу. Бүх хувьсагчаа, бүх татварын төрлөө оруулаад бүх тоогоо оруулаад өмнөх трендээ харж байгаад гоё хамгаал л даа. Хамгаалж чадахгүй байна шүү дээ.

Тэгээд ингээд хоёрын хооронд энэ чинь яг энэ асуудлыг НӨАТ яригдаж байхад зөндөө ярьсан байхгүй юу. Төсвийн байнгын хороон дээр, чуулган дээр тэгээд больчихъё ингэж тэгсгээд төсвийн орлого хэцүү байхад нь хүн амын орлогын албан татвар албан татвар тэгж буух гэж байгаа юм чинь дэмжисхийгээд явчихъя гэж байтал ийм муухай утгагүй тайлбар хийгээд явахаар чинь олон нийт бид нарыг харж байгаа. Аягүй дорой харагдаж байгаа бид нар, аягүй мэргэжлийн бус харагдаж байгаа. Би хүртэл өөрөө эдийн засагч төсвийн аналитист хүн аль болохоор төсвийн орлогыг хамгаалаад даагаад ингээд явж байхад ийм муухай сууж байх чинь аягүй шударга биш байна. Аягүй буруу байна. Би бол бүүр ингээд сонссоор байгаад сүүлдээ.../минут дуусав./

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Засгийн газар ингээд өөрсдөө юм хийе ингээд НӨАТ-ын босгыг 400 сая болгоё гээд оруулаад ирэхэд Улсын Их Хурал дэмжээд л явчихмаар байгаа юм л даа. Би тэгж л логик нь зүгээр наанаасаа. Тэгээд эд нар чинь өөрсдөө ингээд тооцоо судалгаагаа хийчихсэн байна шүү дээ. Би бол Заяа бол гишүүнийг дэмжиж байна.

Яагаад гэхээр би асуулт асууя л даа. НӨАТ-ын босгыг 400 сая болохоор төсөв дээр хэчнээн төгрөгийн ачаалал ирээд байгаа юм? Том аж ахуйн нэгжүүдтэй жижиг аж ахуйн нэгжүүд ерөөсөө харилцаанд ордоггүй гэнэ. 28 мянган аж ахуйн нэгж гэдэг нь мөн юм уу, үнэн юм уу, худлаа юм уу? Тэгээд энэ хууль чинь бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч нараа дэмжихийн тулд тэд нарыг чадваржуулж бойжуулахын тулд орж ирж байгаа хуулийн төсөл гэж ойлгоод байгаа шүү дээ би. Үгүй юм уу? Энэ тийм биш ээ гэж Их Хурал хэрвээ хэлэх гэж байгаа бол шулуухан хэлээд эсрэг байна гээд ингээд байгаа байхгүй юу.

Аливаа нэг юм эргэлт хийхийн өмнө ямар нэгэн юм өөрчлөхийн өмнө дандаа л ийм саад бэрхшээлүүдийг ярьдаг биз дээ? Дандаа л ярьдаг байсан. Сая хэлж байна шүү дээ 50 сая болгоход ярьж л байсан тийм байгаагүй гээд. Одоо хэрвээ 400 сая болгох юм бол яг ямар ач холбогдолтой зүйл үүсэх гээд байгааг тоо баримттай нь бас би эндээс сонсмоор байна мэргэжлийн хүмүүсээс. Тэгээд тодруулъя.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Тайлбар өгье. 1 дүгээр асуудал бол нийтдээ яг 50 саяыг 400 сая болоход бол нийтдээ 161, 2 тэрбумын төсвийн ачаалал ирнэ. Яагаад энэ НӨАТ, НӨАТ гэдэг маань эцсийн хэрэглэгчээс авдаг татвар. Энийг бол бид нар бол бүгдээрээ мэдэж байгаа. Эцсийн хэрэглэгч гэдэг маань бид нарын нөгөө Хувь хүний орлогын албан татварын хууль өргөн барьчихсан болохоор хувь хүний орлогын албан татвараас нэлээн хөнгөлөлтүүд хийчихсэн болохоор энэ удаа НӨАТ-аа больчихъё.

Яагаад гэхээр сая бид нар чинь НӨАТ-ын буцаалтыг нь цуцлаад хаячихсан шүү дээ. НӨАТ-ын буцаалт нь байсан бол магадгүй энэ 400 сая ингээд хамтдаа аятайхан гоё ажиллачих байсан байх. Тэгэнгүүт НӨАТ-ын буцаалт нь байхгүй болчхонгуут энэ 400 сая чинь яах вэ гэхээр энэ чинь аж ахуйн нэгжүүдэд л босгыг нь нэмэгдүүлж өгөх гээд байгаа болохоос биш нөгөө гол энэ чинь НӨАТ-ын татвар гэдэг маань хэрэглэгчээс авдаг татвар байхгүй юу. Бид нар хэрэглэгчид нь энэ чинь хүн амынхаа орлогын албан татвар хөнгөлөлтийг нь хийгээд өгчхөж байгаа байхгүй юу. Урьд өмнө байгаагүй хэмжээнд том хэмжээний хөнгөлөлт хийгдэхээр яригдаж байна.

Өнөөдөр энэ Төсвийн байнгын хорооны дууссаны дараа нөгөө Засгийн газрын өргөн барьсан Хувь хүний орлогын албан татварын хууль, гишүүдийн өргөн барьсан Хувь хүний орлогын албан татварын хуулийн нэгтгэсэн хувилбарыг ингээд Байнгын хорооны гишүүд болон бусад гишүүд тараагдана. Тэр дээрээ та саналаа өгч болно. Тэн дээр та харах юм бол яагаад энэ удаа НӨАТ-ын хуулийг хойшлуулъя, энэ удаа бас цаг хугацаа нь биш юм гэдэг шийдвэр гарсныг та өөрөө ойлгох болов уу гэж бодож байна. Нэмээд хариулбал хариулаарай.

Н.Наранбаатар: Ганзориг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Энэ татварын багц хуулийн асуудал 2024 оны парламент үүссэнээс хойш 3 дахь удаагаа ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Тэгээд энэ аж ахуйн нэгж, ард иргэдийн татварын дарамт ачааг бууруулъя гээд Засгийн газраас ч яах вэ тодорхой төслүүдээ өргөн бариад Их Хурлаас бас ажлын хэсэг гараад гишүүд маань ороод төсвийнхөө байгаа бололцооных нь хэр хэмжээнд орон зайн хэмжээнд нь тултал нь уг нь бол хөнгөлөлт, чөлөөлт чинь гээд яваад байгаа юм. Тэгэхээр бас гишүүд маань зарим асуудал дээр байр суурь эсрэг байж болно. Тэгэхдээ томоор нь бас хэдий хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлтийг бид нар төсөв маань даах боломжтой байгаа юм. Тэрийгээ яаж оруулж ирж байгаа юм гэдгийг бас харвал их зүгээр байна.

Тухайлбал, хувь хүний орлогын албан татвар гэхэд 1.8, 9 их наядын хөнгөлөлт, чөлөөлөлт орж ирж байгаа. Баярмаа гишүүний өргөн барьсан шатлал 1 хувьтай шатлалыг хүртэл оруулчихсан тусгаад л ингээд л уялдуулаад л явж байгаа. НӨАТ дээр гэхэд 181 орчим тэрбум төгрөг. Одоо энэ босгыг хэрвээ 400 сая болгоод нэмэгдүүлбэл. Би бол тухайлбал ажлын хэсгийн гишүүн ч гэсэн, хувь гишүүний хувьд бол тэр 400 болгоод нэмэгдүүлэх энэ Заяабал гишүүний саналыг бол дэмжээд л явж байгаа юм.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр гэхэд тэр шатлал дээр 162 тэрбум төгрөг, жижиг, дунд бизнесийн бизнесүүд дээр буюу нөгөө 1 тэрбумыг 2.5 болгож байгаа шүү дээ. Хялбаршуулсан горимоор 1 хувийн татвар төлж байгаа. Тэр дээр 84 тэрбум гээд нийтдээ 2.4, 5 их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг энэ аж ахуйн нэгж, ард иргэдэд үзүүлэхээр энэ орон зай дээр орж ирж байгаа шүү. Би энэ Сангийн яам, татварын байгууллагууд, энэ мэргэжлийн хүмүүст бол буруу гэж байхгүй ээ Их Хурлын эрхэм гишүүд ээ энэ чинь угаасаа орон зай, бололцоотой юм нь энэ байгаа юм. Энэ хүмүүс бол хуулийнхаа дагуу тооцооллоо хийгээд боломжтой хэмжээнд нь саналуудаа оруулж ирж байгаа юм.

Тэгээд мэдээж энэ Төсвийн байнгын хороон дээр гишүүд өөрсдийнхөө үнэлэлт, дүгнэлтээр, олонхоороо саналаа өгөөд шийдвэрлээд явна. Харин би нэг зүйлийг бас тодотгож хэлмээр байгаад байгаа юм. НӨАТ дээр 5 хувийн буцаалтыг баталчихсан байсан.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут.

П.Ганзориг: Тэгэхээр ингээд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт аль болох үзүүлье гээд ингээд ажлын хэсэг нь ч байна уу зарим гишүүд нь яваад байдаг. Гэтэл НӨАТ дээр бид нар буцаан олголтыг, 5 хувь буцаан олголт байхаар өнгөрсөн намрын чуулганаар баталсан. Тэгээд хэрэгжих байтал сая түрүү 7 хоногийн 5 дахь өдөр Их Хурал өөрөө унагаачихсан шүү дээ энийг. Би бол тэрний эсрэг санал өгсөн. Тэгээд өөрсдөө татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөө олонхоороо ингээд унагаачхаад тэгээд бусад ажиллаж байгаа ажлын хэсгүүд нь бололцоогоороо ингэж санал оруулж ирж байхад томоор нь хараад том энэ хөнгөлөлт, чөлөөлөлт дээр бол муу байна гэж дүгнэх нь бол жоохон өрөөсгөл байх гэж бодож байна.

Тухайлсан тэр НӨАТ-ын босго дээр бол байр сууриуд бол өөр байгаа бол ойлгож байна. Би тэгээд бас тэр 50 саяыг 400 сая болгоод нэмэгдүүлэхийг нь бол дэмжээд явж байгаа. Тэгээд гишүүд бол энэ дээр өөрсдийнхөө саналаар шийдвэрээ Төсвийн байнгын хороон дээрээ гаргаад л ингээд л явах нь зөв байх. Баярлалаа.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: НӨАТ төлөх босгыг хойшлуулахын үр дүнд яг НӨАТ-аас татвараас чөлөөлөгдөж хөнгөлөлт эдэлж байгаа биш зүгээр л жижиг худалдаачны ачаалал нь арай том аж ахуйн нэгж рүү шилжээд оччихож байгаа тэгээд тэндээ бүүр НӨАТ-ынх нь ачаалал нь улам их илүү болж байгаа ийм дүр зураг гараад хүмүүс гомдоллоод байгаа.

Өөрөөр хэлбэл, жишээ нь худалдан авалт хийхдээ НӨАТ-гүй, танайх НӨАТ-гүй юм уу танайхаас авахгүй гэдэг шүү дээ тэгээд НӨАТ-тайгаас нь авна. Дээрээс нь НӨАТ-гүй баахан юмнууд авчхаад буцаагаад нөгөө чинь нэг үйлчилгээ хийгээд НӨАТ-аа төлөхдөө нөгөө худалдаж авсан бараа, материалынхаа НӨАТ-ыг хасуулж чадахгүй. Яг тэр зөрүүгээр нь тэр бараа, материал нь хямдрахгүй. Тэгэхээр зэрэг зүгээр энэ НӨАТ чинь тэр 400 сая хүртэл чөлөөлөгдөж байгаа биш шилжээд энэ талдаа дарамт болоод яваад байна гэж.

Тэгээд ийм тэг НӨАТ гэдэг юм уу, мэргэжлийн нэр томъёо нь ямар байдаг юм байгаа юм. Тэр чөлөөлөх биш 400 сая хүртэл ерөөсөө тэг НӨАТ төлөөд, баримтаараа бүртгүүлээд худалдаж авсан хүмүүс нь дараа нь НӨАТ-аа тайлангаа тооцохдоо 10 хувиар төлсөн мэтээр НӨАТ-ынхаа дүнгээс хасуулж тооцдог.

Ингэх юм бол худалдан авалт дээрээ ч НӨАТ төлөгч төлөхгүй гэж ялгамжтай хандахгүй, жинхэнээсээ энэ ачааллаасаа чөлөөлөгдөх юм байна гэж ийм юм боломжтой юу гэж ажлын хэсгээс асуумаар байна. Ерөнхийдөө ингээд чөлөөлөлт, хөнгөлөлт эдэлчихээр нөгөө төсөв дээр тэдэн төгрөг дутна тэгэхээр яах билээ гээд ингээд төсөв талаасаа дандаа хараад байгаа байхгүй юу. Яг аж ахуйн нэгж дээр үнэхээр бодитой хөнгөлөлт болж очихгүй, зүгээр жижгээс нь арай том руу нь шилжиж яваад том дээрээ илүү ачаалал болгоод тэрийгээ бас цааш нь буцааж татаад байна шүү дээ.

Тэгэхээр 400 сая гэдэг босгыг бол дэмжиж байгаа. Тэр хүртэл зүгээр ийм бичилтгүй биш бүртгээд тэг НӨАТ гэж яваад тэр нь цаанаа НӨАТ төлөгчөөсөө 10-аар төлсөн мэт хасалт хийж явдаг ийм арга байдаг юм уу? Энэ талаар та бүхэн бодож үзсэн үү?

Н.Наранбаатар: Ажлын хэсэг Ганхуяг гишүүн хариулах уу?

Х.Ганхуяг: Үгүй өмнөх бид нар ноднин жилийн боловсруулчихсан байсан НӨАТ-ын хуульд наад санаа чинь байсан юм. Нэг ёсондоо гар дээрээс худалдан авалт хийж байгаа бүх бараа, бүтээгдэхүүнийг И-баримт юм уу, эсвэл мөнгийг нь дансаар нь шилжүүлчихвэл тэр НӨАТ-тай дүн юм гэдгээр тооцдог больё гээд энэ хуулийн төсөл явсан.

Тэгэхдээ таны хэлж хэлж байгаа тэр тийм санал бол юун дээр бол энэ хуулийн төсөл хөндөгдөөгүй. Энэ чинь болохоор зөвхөн тэр НӨАТ төлөгч компанийн асуудлыг л яриад байгаа юм. Тэгэхээр чинь яг таны ярьж байгаа санал

бол яг энэ дээр дуусгахад бол төвөгтэй. Магадгүй НӨАТ 400 саяыг нөгөө ингээд жил явсны дараа нөгөө буцаадаг ч гэдэг юм уу тиймэрхүү хэлбэрээр бол оруулж болно.

Гэхдээ эргээгээд бид нар бол яг юу гэж үзсэн бэ гэхээр, ажлын хэсэг юу гэж үзсэн бэ гэхээр хувь хүн хэрэглэгч юмаа, НӨАТ төлөгч гэдэг маань өөрөө хэрэглэгч байхгүй юу. НӨАТ-ын эцсийн хэрэглэгч нөгөө худалдан авагч нь НӨАТ төлөгч юм. Тэгээд хувь хүн дээр нь хангалттай хөнгөлөлт хийчихсэн байна. Тийм болохоор энэ удаадаа энийг хойшлуулъя гэдэг л санал хураалт хийгдсэн гэсэн үг.

Яагаад гэхээр нэг доор бид нарын төсвийн ачааллаа дийлэхээргүй байна. Нөгөө буцаалттай холбоотой байсан хэсгийг бид нар чинь сая өөрснөө хүчингүй болгочихсон. Тэгээд буцаалттай холбоотой гэсэн хүчинтэй байсан бол энэ 400 сая ингээд явчихвал ямар нэг эрсдэлгүй явчихаар байгаа байхгүй юу тээ? Яагаад гэхээр хүн болгон тэр буцаалттай холбоотойгоор нөгөө НӨАТ-тай бараагаа аваад ингээд НӨАТ-аа төлөөд явчих байхгүй юу. Тэгээд тэр гол бас нөгөө тийм.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Энэ буцаах хуучин хувилбарын талаар бол биш л дээ. Би НӨАТ төлчхөөд буцаах тэгээд тайлангаараа нөхөх талаар биш ерөөсөө НӨАТ-аас чөлөө 400 сая хүртэл чөлөөлөгдсөн гээд байгаа төлөхгүй шүү дээ энэ чинь. Үнэхээр төлөхгүй л юм чинь тэг бүртгэл явуулчхаж болохгүй юм уу? Тэгэхээр яагаад болдоггүй юм бэ л гэдэг асуулт. Тэг бүртгэл явуулаад нөгөө НӨАТ төлж байгаа 10 хувиар төлж байгаа хүн нь авсан материалдаа 10-аар төлсөн мэтээр хасуулж тооцохгүй бол тэгж байж л энэ 400 сая хүртэлх гэдэг чинь жинхэнээсээ чөлөөлөгдөж байгаа. Тэгэхгүй бол зүгээр ингээд ачаалал нь шилжээд яваад байна шүү дээ.

Н.Наранбаатар: Ажлын хэсгээс хариулъя. Чимэдцэрэн.

Ч.Чимидсүрэн: Хэд хэдэн гишүүдийн асуулт дээр бас нэмэлт хариулт болгоод явчихъя. Цаг хүрэхгүй байвал бас нэмээд өгчхөөрэй. Тэгэхээр энэ удаагийн татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт бол Татварын хуулийн багц шинэчлэл бол биш ээ. Зөвхөн нэмэлт, өөрчлөлт явж байгаа. Та бүхэн мэдэж байгаа аж ахуйн нэгж дээр хоёрхон төсвийн нөлөөтэй асуудал яваа.

Нэг нь болохоор нэг хувийн ачааллыг 1.5-2.5 тэрбум босготой болгох. 2 дахь нь 6 тэрбумаас 10 тэрбумын хооронд 15 хувийн шатлал оруулах. Хувь хүний орлогын албан татвар дээр 792 мянга хүртэлх энэ цалинг нь 100 хувийн хөнгөлөлт хэлбэрээр буцаан олгочихъё гэдэг асуудал.

Дээр нь 5 жил өмчилж байгаа орон сууцаа борлуулсан бол 2 хувийн татварыг нь чөлөөлчихье гэдэг асуудал. Тэгээд НӨАТ-ын босго гэсэн ийм цөөхөн төсвийн нөлөөтэй энэ татварын нэмэлт, өөрчлөлтийг л оруулсан. Тэгээд энэ нь бол гадаад дотоодод үүсээд байгаа нөхцөл байдал эдийн засгийн байдалтай холбогдуулаад аж ахуйн нэгж, иргэдийнхээ татварын ачааллыг нь бууруулах, орлогыг нь өөрт нь үлдээх ийм л зорилгыг агуулсан ийм нэмэлт, өөрчлөлтүүд бол орж ирсэн байгаа.

Тэгэхээр би түрүүн ярианд дутуу цаг хүрэлгүй зогсчихлоо. Тэгээд ер нь бол НӨАТ-тай холбоотой НӨАТ-ын хуультай холбоотой болоод системийн

хэрэгжилттэй холбоотой олон асуудал байгаа. Энийг бид нар бас ер нь бол маш сайн нухацтай харж цогцоор нь бол авч үзэх ёстой.

Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татвар бол өөрөө олон шинж чанартай татвар байдаг. 1 дүгээрт нь түрүүн хэлсэн нэмэгдсэн өртгийн албан татвар гэдэг бол бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тэр нэмэгдэж байгаа өртөг болгон нь бол ноогдоод эцсийн хэрэглэгч төлдөг хэрэглээний татвар. Хэрэглээний татвар.

Тийм учраас нөгөө хэрэглэгчдэд өгдөг урамшууллын систем, сугалааны системийг хийж бид нар энэ НӨАТ-ын системийн бүрдүүлэлт, татварын хамрагдалтаа нэмэгдүүлэхийг бол ингээд зорин яваад байдаг юм.

Хоёрт нь бол нэмэгдсэн өртгийн албан татвар бол татвар. Энэ бол зөвхөн тийм бүртгэлийн системийн зохицуулалт биш. Энэ бол татвар.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмээд гүйцээгээд хариулчих.

Ч.Чимидсүрэн: Би тайлбарлаж хэлье. Тэгээд нэмэгдсэн өртгийн албан татвар бол улсын төсвийн орлогын 20 гаруй хувийг бүрдүүлдэг ийм татвар байгаа.

3 дугаарт бол нэмэгдсэн өртгийн албан татвар бол ер нь олон улсын жишигт нийцсэн татвар. Одоо энэ дэлхий дээр 170 гаруй орон нэмэгдсэн өртгийн албан татварыг бол хэрэглээд бол ингээд яваад байгаа шүү дээ. Тэгээд хэрэглээний татвар учраас НӨАТ-ыг бол шударга татвар ч гэж хэлдэг.

Өөрөөр хэлбэл, хэрэглээндээ хамааруулаад төлж байгаа ийм татварууд, татвар бол байгаа. Тэгэхээр энэ цогц хэлбэрээр аваад үзэх юм бол энэ НӨАТ-ын систем тогтолцоогоор нь бол шийдэх ёстой. Одоо 50 гаруй хөнгөлөлт, чөлөөлөлт байна. Энэ чөлөөлөлтийн асуудал байна. Энийг шийдвэрлэх ёстой. Баримт олгодоггүй асуудлыг бид нар шийдвэрлэх ёстой.

Тэгээд эцсийн хэрэглэгчийн яг төлж байгаа татварыг нь багасгая гэж байгаа бол бид нар нүүнийг хэрхэн шийдэх вэ гээд. Энийг бол цогц байдлаар нь харж шийдэх нь бол чухал байгаа юм. Тэгэхээр энэ дээр гарч байсан тодорхой шийдлүүд бол байсан. Тухайлбал, эцсийн хэрэглэгчийн ачааллыг.../минут дуусав./

Н.Наранбаатар: Болсон. Ганбаатар гишүү.

Г.Ганбаатар: НӨАТ бол татвар шүү дээ. Нэмэгдсэн өртгийн албан татвар гээд яриад байгаа биз дээ? Та нар ингээд нэг ярьж, хэлж байгаа зүйлээ эсвэл бүртгэлийн систем болгож яриад, аль өнцгөөс харах дээрээ бүртгэлийн систем гэж ярихаа, аль өнцгөөс харахаараа татвар гэж ярихаа ингээд болих хэрэгтэй байна. НӨАТ бол татвар.

Дээрээс нь бид нар ингээд Улсын Их Хурал, Засгийн газрын энэ уялдаатай холбоотой асуудал байна. Бид нар 11 сарын 14-нд НӨАТ-ын буцаан олголттой холбоотой хууль баталчхаад тэгээд сая яг 5 сарын 14-нд 6 сарын дараа энийгээ буцаасан. Тэгээд тэр үед та нар ингээд энийгээ цогцоор нь ярих байсан шүү дээ.

Одоо тэрийг Их Хурал буцаачихсан гээд бид нарыг 1 дүгээрт буруутгаж байна. Би тухайн үед нь хэлээд л байсан. Гэтэл одоо болохлоор тэр буцаачихсан учраас одоо энэ чинь ерөөсөө явахаа байлаа энийгээ буцаая гэж бүх юман дээр

ухралт хийгээд байна шүү дээ. 400 саяынхаа босго дээр хүртэл ухралт хийж эхлэх гэж байна одоо. Бид нарын яаж ажлаа төлөвлөж, яаж хийж байгаа чинь энэ байхгүй юу.

Ер нь энэ ташрамд хэлэхэд муу хэлэгдээд байгаа Ардчилсан нам чинь 15 онд, 16 онд та нарт засаг өгөхдөө 3, 4 том маш том реформ хийсэн байсан юм. Нэг нь энэ и-баримт энэ НӨАТ-ыг чинь. 2 дугаарт нь тэр муу хэлэгдээд байгаа Эрдэнэтийн 49 хувь. Үүгээр 10 жил амьдарлаа. Одоо энэнээсээ бүгдээрээ ухрах гэж байна. Нэгэнт оруулж ирж байгаа бол тэр саналаа хамгаалаад сур та нар. Тэгээд ингээд тухайн хүний гишүүний асуусан асуултад хариулахдаа эсвэл бүртгэлийн систем болгож яриад, эсвэл татвар болгож яриад энэ чинь болохгүй шүү дээ. Та нар төрийн албан хаагчид тийм учраас оруулж ирж байгаа юмаа хамгаалж сур, ойлгуулж сур, аргумент, факттай ярьж сур.

Тэгэхгүй ингэж буцсаар байтал энэ чинь бид муухай харагдаад эхэллээ. Та нар муухай харагдаад эхэллээ. Энэ ард иргэдийг чинь бид нар яг энэ бүх хуулийг чинь энэ Татварын ерөнхий хууль, НӨАТ-ын хууль, хувь хүний орлогын иргэдийн нуруун дээр байгаа ачааллыг, аж ахуйн нэгжийн нуруун дээр байгаа ачааллыг бууруулах гэж орж ирж байгаа болохоос ийм ямар ингээд байн байн цаг заваа үрээд энэ хэлэлцүүлэг, энэ мэтгэлцээн гэдэг чинь хүн болгон өөр өөрсдийнхөө үзэл бодлыг аргумент, факттай ярьж байна. Тэгээд ингээд хайран байгаа байхгүй юу яг үнэндээ хэлэхэд. Юмаа хамгаалж сур.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналаар санал хураалт явуулна. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Мөн гишүүдээс санал ирүүлсэн. Саналыг уншиж танилцуулъя. Төслийн 2 дугаар зүйлийн “400” гэснийг “1 тэрбум” гэж, “2.5” гэснийг “1” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Тэгэхээр зэрэг одоо ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдчихсэн үү? Санал хураалтад бэлтгээрэй гишүүд.

12 гишүүн бэлтгэсэн байна. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42.1 хувиар дэмжигдсэнгүй.

Саяын тэгээд зөндөө ярьж ярьж.

Төслийн 2 дугаар зүйлийн “400” гэснийг “1 тэрбум” гэж, “2.5” гэснийг “1” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Ажлын хэсгийн 2 дахь саналтай Баярмаа. Санал хураалт.

10.5 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 1 зүйлтэй.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Би энэ дээр нэг юу асуугаадахъя. Энэ оруулж ирсэн танилцуулга дээр байгаа юм олон улсад орлогын болон хөрөнгийн татварын ачааллыг чинээлэг хүмүүст илүү өндөр хувиар ногдуулдаг гээд ийм Онцгой албан татварын тухай танилцуулга дээр байгаа юм.

Тэгээд энэ хуульд энийгээ бол оруулж ирэхдээ 100 мянган доллараос дээш үнэтэй автомашин авсан бол 33 хувийн татвартай гэж ингэж оруулж ирж байна л даа. Тэгээд би 100 мянган доллараос дээш үнэтэй бараа авсан хүн, бүх хүмүүс чинь энэ чинээлэг хүмүүст гэдэгт ангилагдаж байгаа юу гэдэг ийм асуултыг энэ танай оруулж ирсэн танилцуулгатай холбогдуулан асууя. Манай Сангийн яам, хуулийн ажлын хэсгийнхэнд хариулаад өгье.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг Сангийн яам хариулъя.

Ч.Чимидсүрэн: Онцгой албан татвар дээр сүүлийн үед Сангийн яамнаас бол татварын бодлогоор нэмж төрөл нэмэх, бусад татварын орлогоо нэмэгдүүлэх ийм бодлого бол бариад явж байгаа. Тэгээд автомашины хувьд бол үнэ өндөр үнэтэй тийм хэрэглээнд нь бол тавьсан ийм агуулгатай байгаа. Тэрнээс чинээлэг иргэнд гэдэг агуулгаар бол оруулаагүй.

Н.Наранбаатар: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс бэлтгэсэн саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6.10 дахь хэсгийн “100 мянган ам.доллараос” гэснийг “360 сая төгрөгөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн. Булгантуяа гишүүн танилцуулах уу? Санал,

дүгнэлтийг өөр танилцуулах уу? Ганхуяг гишүүн. Гишүүд байж байгаарай. Дахиад нэг.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

18.07 цаг.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс бэлтгэсэн саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “олимпын төрлийн спортын холбоо,” гэснийг “олимп, тивийн наадмын төрлийн спортын холбоо,” гэж өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

2.Саналын томъёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг “ӨӨРЧЛӨЛТ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаан үүгээр дуусаж байна. Гишүүдэд баярлалаа.

18.09 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР